

Орон бүхний пролетариат нар нэгдэгтүн!

АНХДУГААР ТАВАН ЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Х-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь жилдээ

№ 48 (2312)

1974 оны 6 дугаар сарын 22

БЯМБА

Аймгийн Намын XVI бага хурлын тухай СОНСГОЛ МЭДЭЭ

Аймгийн Намын XVI бага хурал 1974 оны 6 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд Зуунмод хотод болов. Аймгийн Намын XV бага хурлаас хойш аймгийн Намын хорооноос зохион явуулсан ажлын тайлан илтгэлийг аймгийн Намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга нөхөр Ц.Адъяа тавьж хэлэлцүүлэв.

Мөн аймгийн Намын хорооны шалган байцаах комиссын тайлан илтгэлийг ШБК-ын дарга нөхөр Д.Сундуй тавив. Бага хурлын хэлэлцсэн асуудалтай холбогдуулж төлөөлөгч, Угтаалын САА-н дарга Б.Батчулуун, Эрдэнэ-санта сум-нэгдлийн хоньчин, БНМАУ-ын аварга малчин П.Базаррагчаа, Жаргалантын сангийн аж ахуйн Намын хорооны нарийн бичгийн дарга Н.Дашням, барилгачин Г.Бор, Алтанбулаг сум-нэгдлийн адуучин С.Банзрагч, аймгийн ЭХ Газрын дарга Б.Галсандорж, Заамар сум-нэгдлийн эдийн засагч А.Чогдон, аймгийн АХШХ-ны дарга Р.Чимэдцэрэн нарын 29 хүн үг хэлж санал шүүмжлэл гаргав.

Аймгийн Намын хорооны XVI бага хурал зохион байгуулалтын асуудал хэлэлцэж, аймгийн Намын хороог

75 хүний, шалган байцаах комиссыг 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр сонгож баталлаа.

Бага хурал хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргав. Бага хуралд МАХН-ын Төв Хорооны гишүүн, Намын Төв Хорооны хэлтсийн эрхлэгч нөхөр Б.Ламжав оролцож дэлгэрэнгүй үг хэлэв. Аймгийн Намын хорооны анхдугаар бүгд хурал болж, аймгийн Намын хорооны товчооны гишүүдэд нөхөр Ц.Адъяа, Х.Билгээ, Д.Гончиг, Ч.Дашдэмбэрэл, Д.Дамбажамц, А.Давааням, Х.Дамдин, П.Жанчив, М.Нямаа, Р.Чимидцэрэн, Н.Шагдардагва нарыг сонгож батлав.

Бүгд хурал аймгийн Намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн даргаар нөхөр Ц.Адъяа, үйлдвэр, худалдаа, тээвэр, холбоо эрхэлсэн нарийн бичгийн даргаар Д.Дамбажамц, Намын зохион байгуулалт, хяналт шалгалтын ажил эрхэлсэн нарийн бичгийн даргаар А.Давааням, үзэл суртал эрхэлсэн нарийн бичгийн даргаар Х.Билгээ, аймгийн Намын хорооны үзэл суртлын хэлтсийн эрхлэгчээр Я.Дамдинсүрэн, "Анхдугаар таван жил" сонины хариуцлагатай эрхлэгчээр Д.Товуу нарыг тус тус сонгож батлав.

Аймгийн намын XVI бага хуралд Намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ц.АДЪЯА-гийн тавьсан тайлан илтгэл*

НӨХӨД ӨӨ!

Аймгийн намын XV бага хурал хуралдсанаас хойш 3 жил гаруй боллоо.

Манай орны хөдөлмөрчид, түүний дотор тус аймгийн ажилчин, малчин, сэхээтнүүд, МАХН-ын XVI их хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн төлөө шаргуу хөдөлмөрлөж, МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойг хөдөлмөрийн амжилтаар угтаж байгаа үед тус бага хурал болж байна. Аймгийн намын байгууллага, гишүүд, хөдөлмөрчид МАХН-ын XVI их хурлаас боловсруулсан намын гадаад дотоод улс төрийн бодлогыг хэрэгжүүлэх талаар МАХН-ын Төв Хороо, нөхөр Ю.Цэдэнбал тэргүүтэй Улс төрийн Товчооны явуулсан үйл ажиллагааг бүрэн дүүрэн сайшааж байна.

Саяхан хуралдсан МАХН-ын Төв Хорооны VIII бүгд хурал дээр нөхөр Ю.Цэдэнбал, улс орны гадаад дотоод байдал, намын XVI их хурлын шийдвэрийг хэрэгжүүлэн биелүүлэх тэмцэлд олсон амжилт, нам, улсын байгууллагын өмнө цаашид тулгарах зорилтыг тодорхойлж дэлгэрэнгүй үг хэлэв.

Намын Төв Хорооны VIII бүгд хурлын шийдвэрийг тус аймгийн намын гишүүд, хөдөлмөрчид баяртай хүлээн авч таван жилийн төлөвлөгөөний 4, 5 дахь жилийн төлөвлөгөөг бүрэн биелүүлэх зориг төгөлдөр байгаагаа илэрхийлж байна. Ардын Их Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн III чуулганы шийдвэр болон манай нам, төрийн гарамгай зүтгэлтэн нөхөр Ю.Цэдэнбалыг БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчийн даргаар сонгож, профессор нөхөр Ж.Батмөнхийг Сайд нарын Зөвлөлийн даргаар томилогч манай бага хурлын төлөөлөгчид сэтгэл гүнээ хангамжтай угтан авч баяр талархлаа дэвшүүлэн амжилтын дээдлийг хүсэн ерөөж байна.

ЗХУ, ах дүү социалист орнуудтай тогтоосон найрамдал, хамтын ажиллагаа, ЗСБНХУ-аас үзүүлж буй зүйл бүрийн тусламж, социализм, коммунизм байгуулж байгаа туршлага нь манай орны хөгжил цэцэглэлтийн үндэс болсоор байна. Саяхан ЗХУ-аас БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойг тохиолдуулан манай улсад тус бүр 964 хүүхэд суралцуулах

10 жилийн иж бүрэн сургууль 2, жилд 70 мянган хавтгай дөрвөлжин метр ашигтай талбай бүхий орон сууц барих хүчин чадалтай байшин үйлдвэрлэх комбинат, Улаанбаатар хотоос Баян-Өлгий аймаг хүртэл радио релейн шугам байгуулахад зориулан 500 сая төгрөгийн барилга байгууламж барих, 60 сая төгрөгийн өргөн хэрэгцээний барааг буцалтгүй тусламж болгон өгөхөөр ЗХУКН-ын Төв Хороо, Зөвлөлт Засгийн Газар шийдвэрлэж, мөн ЗХУ-д гаргадаг махны хилийн үнийг нэмэгдүүлж, Монгол-Зөвлөлтийн хамтарсан уул уурхайн баяжуулах (Эрдэнэт) үйлдвэрийг байгуулах болсон нь манай орны эдийн засаг, соёлын хөгжилтөнд чухал ач холбогдолтой зүйл юм.

Зөвлөлтийн тусламж бол манай хоёр орны найрамдал, ах дүүгийн харилцааны яруу тод нэрэл мөн. ЗХУ-ын тусламжаар тус аймгийн ХАА-н үйлдвэрлэлийн баазыг хөгжүүлэх хэтийн төлөв, техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулж батлуулсан нь манай хөгжлийн төлөвийг яруу тод болгож байна.

Манай аймаг, ЗСБНХОУ-ын Курган мужтай шууд харилцаа тогтоож, төлөөлөгчдөө солилцон, хамтран ажиллах хэлэлцээр хийв.

Энэ нь ЗХУ-аас суралцах сайхан бололцоог бий болгов. Манай аймагт ЗХУ-ын хүч хөрөнгө, мэргэжилтний тусалцаагүйгээр бий болсон нэг ч үйлдвэр, ХАА, соёлын салбар байхгүй юм. Мөн Зөвлөлтийн тусалцаагаар тохижуулсан ХАА-н нэгдэл, ТАА-нуудад олон тооны мэргэжилтэн ажиллаж байна.

Мөн манай САА, ХАА-н нэгдлүүд орчин үеийн шинэ машин техникээр хангагдсан байна.

Тайлангийн хугацаанд ЗХУ-ын зээл тусламжаар иж бүрэн механикжсан сүүний ферм 10, үтрэм, үрийн хэд хэдэн агуулах баригдаж байна. Манай орны эдийн засаг, соёлыг хөгжүүлэх, улс орныг батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэхэд бүх талын сэтгэл харамгүй тусламж үзүүлж байгаа Зөвлөлтийн ард түмэн, ЗХУКН-ын Төв Хороо, Зөвлөлт Засгийн газарт тус бага хурлын өмнөөс чин сэтгэлийн халуун баяр хүргэе.

Марксизм-Ленинизмын үзэл санаанаас ухарч ЗХУ тэргүүтэй дэлхийн социалист систем, коммунист хөдөлгөөний эсрэг улайран дайрч байгаа Мао-гийн бүлгийн харгис үйл ажиллагааг тус аймгийн намын байгууллага,

Манай ажилд гарч байгаа зарим ололтыг ярихдаа, бид хөдөлмөрийнхөө үр дүнд шүүмжлэлтэй хандаж, олсон амжилтаа тайвшралгүй, бүх анхаарлаа шийдвэрлэгдээгүй асуудалд төвлөрүүлэн, ашиглагдаагүй нөөц бололцоог ашиглаж ажлынхаа чанарыг бүх талаар дээшлүүлэх хэрэгтэй.

(МАХН-ын Төв Хорооны VIII бүгд хурал дээр нөхөр Ю.Цэдэнбалын хэлсэн үгнээс)

НЭД. Эдийн засаг бол намын ажлын гол фронт мөн

НӨХӨД ӨӨ!

Сүүлийн 3 жил хагасын дотор эх орны эдийн засгийг хөгжүүлэх тэмцэлд олсон амжилт бүтээлд тус аймгийн хөдөлмөрчдөөс оруулсан хувь нэмэр багагүй юм.

МАХН, Ардын хувьсгалын болон Төв аймаг байгуулагдсаны 50 жилийн ойнуудыг угтаж, аймгийн нийт хөдөлмөрчид социалист уралдаан өрнүүлэн ажиллав. Таван жилийн төлөвлөгөөний эхний 3 жилийн зорилт яаж биелнийг ажлын салбаруудаар авч үзье.

Ходоо аж ахуй

Нам, засгаас ХАА-г хөгжүүлэх, хөдөөгийн хөдөлмөрчдийн аж байдал, соёлын хэмжээг дээшлүүлэх олон чухал арга хэмжээ авлаа.

Мал аж ахуйн бүтээгдэхүүний улсын бэлтгэлийн үнийг нэмэгдүүлж, төлөвлөгөө биелүүлсэн ба давуулсанд олгох урамшил, зээлийн системд өөрчлөлт оруулж, нэгдэлд урьд олгосон зээлийн заримыг чөлөөлөх, МАА-н материаллаг бааз байр төжөөл, усаар хангах, нэгдлийн дэргэдэх цэцэрлэг, ясли, сургуулийн дотуур байрны зардлыг улсын төсвөөс хариуцаж болов.

Мөн усалтын систем барих, түүний техник төхөөрөмж, ашиглалтын эхний 3 жилийн зардлыг хөрөнгө оруулалтаар олгож байхаар шийдвэрлэв. Бас гинжит ба дугуйт трактор, ХАА-н машин түүний сэлбэг, дизелийн шатахуун, бензиний бөөний үнийг нэмэгдүүлэх болж байна.

Эдгээрээс манай аймгийн нэгдлүүд 3 жилд

*Товчлон нийтлэл

Нөхөр Ц. АДЪЯА-гийн тавьсан илтгэлийн үргэлжлэл

Үргэлжлэл. (Түрүүч нь I нүүрт)

нийтдээ 14 сая гаруй төгрөгийн мөнгөн орлого олж байгаа нь ХАА-н нэгдлийн эдийн засгийг бэхжүүлж хөдөөгийнхүн амын ахуй амьдралын дээшлэлтэд сайхан нөлөө үзүүлж байна. Энэ үндсэн дээр нэмэгдэл хөдсний системийг шинэчилснээр аймгийн нэгдлүүд 3 жилд 1,2 сая төгрөгийн нэмэгдэл хөдс гишүүдээ олгожээ.

Тайлангийн хугацаанд хашаа барих, худал гаргах, өвс тэжээл бэлтгэх зорилтууд жил дараалан амжилттай биелэгдэв. Хадлангийн механикжсан бригад 30 гаруйтай болж тэжээл фондын контор байгуулагдсан.

Мал аж ахуйн материаллаг бааз бэхжиж, тэжээл бэлтгэлт 33,3 хувь өсч, хашаа 778, худал уст цэг 361-ийг барснаар аймгийн хэмжээний бод 1, бог мал 1,5 ээлжийн хашаагаар хангагдаж, бэлчээрийн 85,6 хувьд уст цэгтэй болов.

Аймгийн Намын хороо тайлангийн хугацаанд мал сүргийн тогтвортой өсөлтийг хангах, ашиг шинийг дээшлүүлэхэд зохион байгуулалт, үзэл суртлын ажлаа чиглүүлэв.

Намын хорооны бүгд болон товчооны хурлаар мал аж ахуй, түүний эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, малыг отор бэлчээрээр таргалуулах, төл бойжуулах, үйлдвэрлэлийг удирдах арга барил технологийг сайжруулах асуудлууд хэлэлцэж, тодорхой зорилтууд дэвшүүлэн хэрэгжүүлж байна. Мал сүргийг тогтвортой өсгөх гол зангилаа болсон отор бэлчээрээр мал таргалуулах явдал аймгийн нам, улс, ХАА-н байгууллагын анхаарлын төвд байлаа. БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Б. Ажваагийн туршлагын аргачлал боловсруулж, тэнд туршлагын үзүүлэх сургууль явуулан Б. Ажваагийн туршлагаар зурагт хуудас, товхимол хэвлүүлж суурийн хүмүүжлээр бүх малчдад хичээллүүлж уг туршлага эзэмшигчдэд гэрчилгээ олгож байна. 1973, 1974 онд мал таргалуулах бүх нийтийн аянд зориулан тарган мал тал бүрийн ашигтай гэсэн сэдвээр зоо-эдийн засгийн бага хурал зохиов.

Завхан аймгийн Сантмаргац сумын туршлагаар мал оторлох, үлдсэн суурь, малчдаар өргөн айлсалт хийх эхлэлт Угтаал, Баян-өнжүүл, Эрдэнэ-сант, Баянцогт, Мөнгөнморьт зэрэг нилээд сумдад гарав. Үлэмж гандсан 1972 онд мал сүргийг мэнд оруулах, өвлийн отрыг зөргөлдөө аймаг сумдад хийснээр байгалийн бэрхшээлийг харьцангуй бага хохиролтой давсан

юм. Бараг бүх бригадэд эмчилгээ тэжээлийн цэг байгуулж, үнээ хээлтүүлэгт зохиомол гардан аргыг голчилж, гүн хөлдөөсөн үр хэрэг-лэж техникийн хуанли хөтлөж хээлийн шалгалт хийх, нийлүүлгийн үсгийн хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулж, төлийн бэлтгэл бойжилтонд дэвшилтэт технологи хэрэглэх талаар зарим ахиц гарав. Өвөлжилт төлийн бэлтгэлийн сум, бригад, суурнар шатлан хүлээн авах, дутууг хугацаа тавин хийлгэж, дахин шалгах, үлгэр жишээ сайн бэлтгэсэн газарт туршлагын үзүүлэх сургууль, нийтийг хамарсан семинар зөвлөдөгөн зохиож ирлээ.

Түрүүчийн бага хурлаас мал сүргийг өсгөх талаар тавьсан зорилтыг үндсэнд нь биелүүлж хорогдлыг 1971 оныхоос 35,3 хувиар багасган, төлөө 93,2—94,4 хувиар бойжуулж, 1972 онд 69,0 мянга, 1973 онд 83,1 мянган мал нэмэгдүүлж, 1973 онд мал өсгөх хөдлөшгүй төлөвлөгөөг дүнгээр нь 100,3 хувиар биелүүлэв. Энэ бол аймгийн нийт мал, түрүүчийн бага хурлын үзэс 83,0 мянгаар буюу нэг томхон сумын мал нэмэгдлээ гэсэн үг юм. Угтаал сум, САА V таван жилийн мал өсгөх хөдлөшгүй төлөвлөгөөг эхний 3 жилд таван төрөл дээр нь биелүүлж, Борнуур, Баянжаргалан, Эрдэнэ-сант, Бүрэн, Эрдэнэ, Алтанбулаг сумд ерөнхий дүнгээрээ мал өсгөх 5 жилийн төлөвлөгөөг давуулан биелүүлэв. Аймгийн бүх үхрийн 10,6, хонины 11,9, ямааны 1,8 хувийг цэвэр ба эрлийн мал эзлэх болж, малын ашиг шин нэмэгдэх боломж өсч байна. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулж, мал бэлчээрээр таргалуулан, төлөх малыг эрт тэжээлд оруулж, эх төлийг ногоотой залгалал тэжээж мал маллагааны арга технологийг малчдад эзэмшүүлж социалист урдалаанд бүтээлч хамарч хөгжүүлэн тэдний хариуцлага санаачилгыг өндөржүүлсэн газарт амжилт олджийг Угтаал, Эрдэнэ-сант сумдын үйл ажиллагаа нотлож байна. Эдгээр сум малын хорогдол, хээл хаялт, сувайралт, ашиг шин ашигдалтыг судлаж дүгнээд нийт малчдад дутагдал, зорилтыг ухамсарлуулж авах арга хэмжээг оновчтой хийж чадсан нь амжилт олохын үндэс болжээ. Говч мал аж ахуйн үйлдвэрлэлийг удирдах ажилд ихээхэн дутагдал оршиж байгаагаас 3 жилд 215,6 мянган том мал, 129,0 мянган төл хорогдол, 321,0 мянган мал хээл хаяж, сувайрсан ноотой дутагдал оршиж байна.

Дэлгэрхаан, Баян, Баянцагаан, Сэргэлэн, Баянзүрх, Мөнгөнморьт, Лүн сумд мал өсгөх

улсын төлөвлөгөөг жил дараалан тасалжээ. Чухамдаа эдгээр сумдын намын байгууллага үйлдвэрлэл, олон түмний гүнд орж эдийн засаг, аж ахуйн ажиллагаанд нухацтай дүн шинжилгээ хийж, аж ахуйг удирдах намын удирдлагын талаар Төв Хорооны удаа дараагийн бүгд хурлын шийдвэрийн үндсэн дээр ажилдаа дүгнэлт хийж арга барилаа өөрчлөн сайжруулахыг удаашруулж, цаг алдсан ба зохион байгуулалт, үзэл суртлын ажил нь олон түмнийг тэмцэлд дайчлах, зохион байгуулах нөлөө муутайгаас үйлдвэрлэл тодорхой үр нөлөөгөө тусгаж чадаагүйтэй холбоотой гэж үзэж байна. Олон газарт заазалсан ба өвчний сэжигтэй малыг ялгаж суурилан таргалуулах, эмчлэх, урьдчилан сэргийлэх ажил хангалтгүй үржлийн ажил замбараа муутайгаас сүүлийн 3 жилд зүй бусаар хорогдсон нийгмийн малын 55,3 хувь нь өвчнөөр, 26,9 хувь нь малчны хариуцлагагүйгээс хорогджээ. Энэ дутагдлын гол шалтгаан бол аймаг сумдын нам, улс, олон нийт, ХАА-н байгууллагаас МАА-н үйлдвэрлэлийн гүнд орж тодорхой удирдах шаардлагыг хангаагүй үйлдвэрлэгчдэд зорилцаж, ажил аргыг бүрэн ойлгуулж хөдөлмөрийн идэвхийг төрүүлэн социалист уралдааны далайцтай өрнүүлж, шинжлэх ухааны ололт, тэргүүн туршлагыг нэвтрүүлэх, гүйцэтгэлийн шалгалтын үр нөлөөг өндөржүүлж жинхэнэ гүйцэтгэлийг дүгнэж малчид, мэргэжилтний идэвх санаачлага, намын гишүүдийн манлайллыг байнга дээшлүүлж чадаагүй, удирдах арга барил ерөнхий, суурь, малчин бүрийг идэвхжүүлэх ажлын дутагдалтайг оршино. Үүний улмаас доорх үндсэн асуудал ХАА-д шийдвэрлэгдэж чадаагүй байна. Энэ нь:

1. Аймгийн хэмжээгээр бод малын өсөлт нэн хангалтгүй, сүүлийн 3 жилд 408 тэмээ, 17,5 мянган адуу хорогджээ. Энэ бол бод малын нийлүүлэг арчилгаа, хариуцлага, төл бойжуулах ажилд үлэмж доголдол оршиж 3 жилийн дунджаар 100 хээлтэгцээс унага 46, тугал 61-ийг авч байгаа нь маш хангалтгүй хэрэг юм.

2. Өвөлжилт, төлийн бэлтгэлийг урин дулааны нөхцөлд гүйцэтгэж сайн хийхгүй байна. Иймээс өвлийн хүйтэн, хаарын хаасрага мал төлөх үед хашаа хороо дулаалаагүй, хэвтэр бууц бэлтгээгүй, тэжээл татаагүй байх явдал олон тохиолддог.

(Үргэлжлэл нь III нүүрт)

Аймгийн намын XVI бага хурлаас сонгогдсон аймгийн Намын хорооны бүрэлдэхүүн АЙМГИЙН НАМЫН ХОРООНЫ ГИШҮҮД

- | | | |
|--------------------------------|-----------------------------|--------------------------------|
| 1. Цэндийн Адъяа | 26. Ядамын Должинжав | 51. Жанчивын Рэнцэндорж |
| 2. Балдангийн Ажваа | 27. Пүрэвжавын Дорж | 52. Марсаржавын Саарай |
| 3. Гончигжавын Алтанхүү | 28. Бизъяагийн Доржсүрэн | 53. Даваагийн Санжаа |
| 4. Даваажавын Вавуу | 29. Сэвжидийн Доржсүрэн | 54. Дорлигийн Сундуй |
| 5. Сономын Бадамсүрэн | 30. Чойжинзавын Дугарсүрэн | 55. Жаламбын Сүрэнжав |
| 6. Ёндонжунай Банзрагч | 31. Үнэнбуянгийн Ёндонжунай | 56. Данзангийн Товуу |
| 7. Сампилын Банзрагч | 32. Далантайн Ёндон | 57. Борбандийн Түдэв |
| 8. Пунцагдоржийн Базаррагчаа | 33. Гэндэнгийн Жалбаа | 58. Гэндэнжавын Хандсүрэн |
| 9. Бэгзийн Батчулуун | 34. Жанцангийн Жамъян | 59. Гомбожавын Ханхярваа |
| 10. Хандын Билгээ | 35. Дамдины Жамбалдорж | 60. Цэрэндоржийн Хорлоо |
| 11. Гомбосүрэнгийн Бор | 36. Пэрэнлэйн Жанчив | 61. Готовын Цогбадрах |
| 12. Тамзавын Гаваа | 37. Ойдовын Лхамсүрэн | 62. Жамъянгийн Цэнд-аюуш |
| 13. Баярмагнайн Галсандорж | 38. Буриадын Лувсан | 63. Цэрэндуламын Цэрэндаш |
| 14. Дамдиндоржийн Гончиг | 39. Пунцагийн Лувсанбалдан | 64. Маахүүгийн Чимгээ |
| 15. Ширэнгийн Готов | 40. Жанцангийн Мөнхтоогоо | 65. Ролжинсүрэнгийн Чимэдцэрэн |
| 16. Дашинмын Даваажав | 41. Бавуугийн Намсрай | 66. Намжилсүрэнгийн Чогсом |
| 17. Аюушийн Давааням | 42. Дугарын Намхай | 67. Дондогийн Чойжил |
| 18. Балжидын Дагвадорж | 43. Цэрэндагвын Насантогтох | 68. Долгосүрэнгийн Чулуун |
| 19. Дэндэвийн Дагдан | 44. Баярын Норжин | 69. Долгорын Чүлтэм |
| 20. Долгосүрэнгийн Дамбадаржаа | 45. Гашийн Норов | 70. Норсүрэнгийн Шагдардагва |
| 21. Дэжидийн Дамбажамц | 46. Сандагийн Нэргүй | 71. Балжиннямнын Шагжав |
| 22. Хувхүүгийн Дамдин | 47. Мандаагийн Нямаа | 72. Гомбосүрэнгийн Шарав |
| 23. Ядамсүрэнгийн Дамдинсүрэн | 48. Янживын Нямаа | 73. Төгсийн Ширчин |
| 24. Човдронгийн Дашдэмбэрэл | 49. Санжжавын Оюун | 74. Базарын Ягаан |
| 25. Намжилжавын Дашням | 50. Бүсрэнгийн Осоржам | 75. Жагдарын Ядам |

Аймгийн намын XVI бага хурлаас сонгогдсон аймгийн намын шалган байцаах комиссын гишүүд

- | | | |
|------------------------|----------------------------|-----------------------------|
| 1. Дүгэржавын Барьд | 5. Ядамсүрэнгийн Должинжав | 9. Цагааны Норлохоо |
| 2. Адигжавын Гончиг | 6. Шаравын Доржпалам | 10. Цэдэвийн Сэр-Од |
| 3. Чүлтэмийн Далхсүрэн | 7. Гончигийн Магвандорж | 11. Дэнсээхүүгийн Цэнд-Аюуш |
| 4. Ганжуурын Довдон | 8. Лхагвасүрэнгийн Молам | |

ХАНЫН СОНИН, ҮЗҮҮЛЭН

Аймгийн намын XVI бага хурлын үеэр намын байгууллагуудаас гаргасан ханын сонин, үзүүлэнгээр үзэсгэлэн байгуулж шалгаруулан байр эзлүүлэв. Нэгдэл, САА-н намын үүр, хороод, Зуунмод хотын зарим үүрийн ханын сонинг шалгаруулж байр эзлүүлэхэд Баянцогтын САА-н намын хорооны «Бүтээлч», Өндөрширээт сумын намын үүрийн «Бүтээлч», Баяндэлгэр сумын намын үүрийн «Манлайлагч» сонин эхний 3 байр эзлэв. Мөн намын байгууллагуудын бэлтгэж тавьсан үзүүлэн (сурталчлах булан)—г нэгдэл, САА, Баянчандмань хороо, Зуунмод хотын хорооны гэж хоёр хэсэгт шалгаруулахад САА, хот, хороодын үзүүлэнгүүдээс Угтаалын САА-н үзүүлэн 1 дүгээр байр, Батсүмбэрийн САА-н үзүүлэн 2 дугаар байр, Жаргалантын САА-н үзүүлэн 3 дугаар байр эзлэв. Нэгдлүүдийн намын байгууллагын үзүүлэнгээс Өндөрширээт, Бүрэн, Алтанбулаг сумд 1, 2, 3 дугаар байр эзэллээ. Үүнээс гадна Угтаалын САА-н намын хорооны «Манлайлагч», Баянжаргалангийн намын үүрийн «Амьдрал» зэрэг сонин ур хийц, утга агуулга сайтай болжээ.

Намын байгууллагуудын ханын сонин, үзүүлэнгээр үзэсгэлэн байгуулж сурталчилсан нь сумдын намын үүр, хороод ухуулгын ажлын туршлагаа харилцан солилоход чухал ач холбогдолтой боллоо.

МАНАЙ СУРВАЛЖЛАГЧ

Нөхөр Ц. АДЪЯА-гийн тавьсан илтгэлийн үргэлжлэл

Үргэлжлэл (Түрүүч нь II пүүрт)

3. Нэгж малаас ашиглах ноос, мах, сүүний гарц хангалтгүй байна. Мал ноослох ашигтай хугацааг сонгон малыг зөв технологигоор ноослох явдал олонтаа нэвтрээгүй нь цаг алдаж, төлөвлөгөө тасалдаж, чанар доройтох шалтгаан болж байна. Малын ашиг шим ашиглах явдал хангалтгүй байгаа нь нийслэлийн хөдөлмөрчдийг ХАА-н бүтээгдэхүүнээр хангах гол үүргээ биелүүлэхэд муугаар нөлөөлж байна.

4. Өмч хамгаалалт, бүртгэл хяналтын ажил муу, малыг олноор алдаж дутагдуулах, нийгмийн хөрөнгийг элдэв хэлбэрээр буудал зээл өгч өр тавих, үрэлгэн явдал хэвийн биш байдалтай байгааг анхаарахгүй байж болохгүй.

Аймгийн хэмжээгээр өр авлага 3 жилийн өмнөхөөс 17,7 хувь багассан боловч 16,8 сая төгрөгийн өр авлагатай байгаа нь төсвэрлэж үл болох дутагдал мөн.

5. Социалист уралдаанд тооцоо үндэслэл түшиглэн нөөц боломжийг эрж хайсан, шахуу үүрэг амлалтыг тасаг бригад цехийн хамтлаг хувь хүмүүсээр жинхэнэ ухамсар идэвхийг төрүүлэн авахуулахын оронд дээрээс нэг хэв загвароор авахуулж байгаагаас хөдөлмөрийн хамт олон, хүн бүрийн идэвх эрмэлзлэлд нөлөөлөх хүчин зүйл болж чадахгүй байна.

V таван жилийн төлөвлөгөөнөөс дутуу байгаа адуу 29,3, үхэр 32,8 мянга, тэмээ 404-ийг үлдээ 2 жилд нөхөхийн тулд 1974 онд мал өсгөх хөдөлгөөг төлөвлөгөөг төрөл бүр дээр нь биелүүлж, дүнгээр нь 1975 оны хэмжээнд хүргэх, зүй бус хорогдлыг өнгөрсөн 3 жилийн дундаас 33,2 мянга, төлийн хорогдлыг 53,3 хувиар багасгахаар аймгийн Намын хорооны VI бүгд хурлаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх нь манай хамгийн гол зорилт мөн.

Үүний тулд зун, намар цагийн сайханд тайвшралгүй, малын зүй бус хорогдолтой тэмцэх ажлыг эрчимжүүлж, үүнд тавих хяналтыг шаргуу явуулж ялангуяа хээлтэгч бодмал бүрээс төл авах шаардлагатай байна. Иймд 1974—1975 онд мал төлүүлсэн суурийн олонх МАХН-ын Төв Хорооны IX бүгд хурлын шийдвэрийг биелүүлэх ба давуулан биелүүлэх зорилтыг бага хурлаас дэвшүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Малаа таргалуулахын тулд жилийн 4 улиралд бэлчээрийг хуваарьтай ашиглах, нүүдэллэх төлөвлөгөө графикийг ажил хэрэгчээр зохиож мөрдөн, хол ойрын болон бэлчээр хонгологх отор, өргөн айлсалт, түнд соёл ахуй үйлчилгээг хүргэдэг сонгомол аргыг ойрын жилүүдэд бүрэн нэвтрүүлбэл зохино.

—Хашаа худгийн чанар муу, барих хугацаа удаашралтайд анхаарч хашаа байргыг иж бүрнээр 7 дугаар сарын 10-ны дотор барьж байх шаардлагатай байна. Өмчилгээ тэжээлийн цэгийн ажиллагааг сайжруулж түүний үр ашгийг өндөржүүлэхэд онцгой анхаарах хэрэгтэй. Төрөл бүрийн тэжээлийг хямгатай зарцуулж, кг тэжээл бүрийг мөнгөөр тооцож байвал зохино. Ялангуяа саалийн фермийн дэргэд тэжээл боловсруулах цех байгуулж өвсний гурил, сенаж бэлтгэх, царгас, ерхөг, өвөлжих хөх тариа зэргээр таримал бэлчээр бий болгож, услах боломжийг эрж хайх нь чухал байна. Бод малыг жилийн дөрвөн улиралд богчлон хариулах, үнээг сүүний тасгаас зайдуу, хэсэг хэсгээр буулган богино хугацаанд нутаг сэлгэх, адууг хээлтүүлж, төлөөлтийн үед байнгын хариулга, манаатай болгон азарга, азаргаар хэсгэлэн маллах хэрэгтэй.

Механикжан фермүүдийн технологийг малчид мэргэжилтнүүдэд эзэмшүүлэн, үр ашгийг дээшлүүлэх, сүргийн дотор хээлтэгч малын эзлэх хувийн жинг 5—10 хувиар нэмэгдүүлэх, нутгийн шимлэл сүргийн суурь байгуулах, эрлийзжүүлэх зэргээр ашиг шинийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Илгээлтийн эздийг тогтвор үр бүтээлтэй ажиллуулах нөхцөлийг бүрдүүлж ахмадын хөдөлмөрч уламжлалар хүмүүжүүлж, ажлыг нь тодорхой дүгнэж урамшуулах талаар их ажил хийх ёстой.

—Мал аж ахуйн хэсэг зохион байгуулалтыг 1975 онд дуусгаж, тэнд намын удирдлагын үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай байна.

—Яагаад мал хээл хаяж сувайрч, зүй буцаар хорогдож, ашиг шим дутуу ашиглагдаж байна вэ? гэдэгт олон жилийн судалгаа дүгнэлт хийж, доголдлыг засах арга замыг шинжлэх ухааны үндэстэй боловсруулан олон түмнээрээ хэлэлцүүлж, амжилт олж байгаа төргүүний байгууллагын туршлагаас бид бүтээлчээр суралцах ёстой. Үүнтэй уялдуулан малч-

дын бага хурал, залуучууд эмэгтэйчүүдийн хөдөлмөр соёлын чуулга уулзалтыг бэлтгэл зохион байгуулалт сайтай явуулж байх нь зүйтэй. Аймгийн Намын хороо Газар тариалангийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөт зорилтыг биелүүлэх түүнийг хөтлөн явуулах арга бари-лыг сайжруулах талаар 1972 онд бүгд хурлаараа хэлэлцэж, намын байгууллагын өмнө тодорхой зорилт дэвшүүлсэн юм.

Тариалт хураалтын ажлыг үечлэн хүлээн авах, хөрсний хавь боловсруулах, налсан тариаг хаягдалгүй хураах, хадлангийн ажлыг механикжуулах зэрэг сэлбээр аймгийн газар тариалангийн мэргэжилтэн зарим төргүүний тариаланчдыг оролцуулан үзүүлэх туршлага сургууль хэд хэдэн удаа зохиов.

Хөрсний салхины эвдрэлээс хамгаалах, бордох, услах, хортон шавьж хог ургамалтай химийн аргаар тэмцэх, зурваслах ба тоонолжилж тариалах, ангилан хураах зэрэг дэвшилтэт агро-аргуудыг хэрэглэж байна.

Зөвхөн 1973 онд 28,5 мянган га-г эрдэс ба шимт бордоогоор бордон, 18000 га талбайд цас тогтоож, 23,5 мянган га-гийн ургацыг гэнэтийн хүйтрэлт, хяруунаас хөшгөн утаа тавьж хамгаалсан нь хойшид ч давтан хэрэглээл зохих үр дүнтэй арга хэмжээ болсон юм. Тайлангийн хугацаанд 15 морины хүчинд шилжүүлснээр трактор 2070-тай болж нэмэгдэн, ХАА-н техникийн парк ашиглалт 1973 онд 1972 оныхоос 23 хувь, хүчин чадлын ашиглалт 17 хувиар дээшлээ.

Үр тариа, төмс, хүнсний ногооны га-гаас авсан ургац 1973 онд 1971 оныхоос 56,3—81 хувиар өсчөө. Ялангуяа бүх ард түмний социалист уралдааны жилд аварга ургац авсан нь 1970, 1971, 1972 онд аймгийн хэмжээгээр хураасан үр тарианы 72,8, төмсний 73,6 хувьтай, хүнсний ногооны ургац нь 1971, 1972 оны нийлбэртэй тэнцэж байна.

Ийм амжилт гаргасан учир тус аймаг Засгийн газрын хүндэт жуух бичгээр шагнагдлаа. Гэхдээ тариалангийн бүх бололцоог бүрэн ашигласаа гэсэн хэрэг огт биш юм. Үлэмж илүү ургац авах нөөц байсаар байна.

Техникийн засварын чанар жигд сайжраагүй, мэргэжил дутмаг, техник хүрэлцээгүй, нутагшсан сортын үрийн учир холбогдлыг дутуу үнэлсэн зэргээс агротехникийн хугацаа алдаж хураан авах ургацын нөөцийг алдагдуулж байна. ХАА-н нэгдэл, түүний дэргэдэх намын байгууллагууд газар тариалангийн үйлдвэрлэлийг тодорхой удирдлагаар хангаж, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд хангалтгүй анхаарч байна.

1972 онд уриншийн төлөвлөгөөг тасалдуулж, хөрс эдэлжүүлэх агро-техникийн шаардлагыг хангаагүйгээс Алтанбулаг, Сэргэлэн, Бүрэн сум—нэгдэл цаг уурын хамгийн тааламжтай жил 1973 онд төмс, хүнсний ногооны ургацын төлөвлөгөөг тасалдуулаа. Борнуур, Жаргалант, Батсүмбрийн САА усалттай системийн төслийн хүчин чадлыг бүрэн ашиглаж чадаагүйн дээр төмс, хүнсний ногоо тариалах ажлыг олонх нэгдэлд чанаргүй хийж байна. Тариалт хураалтын техник засварас бусад бэлтгэлд бага анхаарч ургац хураалтын ид үед сэлбэг, аж ахуйн хангамж дутагдсанаас бригадын дарга, тоо бүртгэгчид энэ ажлаар хөөцөлдөж, үйлдвэрлэлийн хөдөлмөр зохион байгуулалт, хяналт шалгалтаас хөндийрөх, техникийн эвдрэл саатай гарч цаг алдах явдал байна. Төргүүний тариаланчдын улсын зөвлөлгөөний уриалга, агро-техникийн шаардлагыг хатуу мөрдөж, тариалантын төлөвлөгөөг ургамлын нэр төрлөөр биелүүлж төлөвлөгөө давуулж тарьсны аль нэгээр нөхөх гэдэг буруу практикийг эцэс бологовол зохино.

V таван жилийн төлөвлөгөөний эхний 3 жилд улсад тушаах ургацаас дутуу байгаа 16,2 мянган тонн үр тариа, төмс 1018 тонн, хүнсний ногооны 4174 тонн-ыг үлдэж байгаа 2 жилийн төлөвлөгөөн дээр нөхөн биелүүлэх зорилт тавигдаж байна. Энэ нь зориудын арга хэмжээ авахгүйгээр хялбархан бүтэх зүйл биш ээ. Энэ зорилтыг хэрэгжүүлэхэд хөрс боловсруулалтын чанарт тавих удирдлага хяналтад онц анхаарах хэрэгтэй. Химжүүлэх, ганд төсвөр бүхий эрт болцын сортыг сонгон тариалах, системийн ашиглалтыг сайжруулж аль болохоор услах, ногооны үрийг өөртөө бэлтгэх, үрэлтгээг сайн хийж ногоо тариалтын чанарт анхаарч метр квадратад суулгах ургамал, суулганын тоог нэмэгдүүлэх бүх төрлийн тэжээл, олон наст тариалах, хөдөлмөр зохион байгуулалтыг төгөөржүүлэх хэрэгтэй.

Үр тариа, төмс, хүнсний ногооны соёлол, уринш боловсруулалт хураалтын чанарыг шалгаж бригад салаа, тариаланч механикжуулагчдын ажлын чанарт үнэлэлт өгч түүгээр нэмэгдэл шагнал олгох шинэ журам тогтоож байна.

Үүний ач холбогдлыг нийт тариаланчдад ухамсарлуулж тэдний мэргэжил, хариуцлагыг байнга дээшлүүлэх хэрэгтэй.

—Манай орны нөхцөлд тогтвортой ургац авах үндэс болсон хөрсний уриншлах ажлыг технологийн шаардлагын дагуу хийж, тариалах талбайн 40-өөс доошгүй хувьд хүргэн талбайг хог ургамлаас цэвэр байлгаж зорилт тавигдаж байна. Хөрснийг зөв элдэншүүлэх, салхи усны эвдрэлээс хамгаалах 1974 оны ургац хураалтанд сайн бэлтгэх тухай МАХН-ын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлийн чухал тогтоол гарав. Хөрснийг эвдрэлтэй тэмцэхэд хавь боловсруулах ба үрлэх уринш таримлыг зурваслан байршуулах, хооронд нь олон наст өвсний зурвас бүхий ээлжлэн тариалалт хэрэглэх, цас тогтоох зэрэг технологийг ээлж дараатай нэвтрүүлбэл зохино.

—Тариаг хаягдалгүй хураахын тулд комбайныг чигжиж, нэмэгдэл төхөөрөмж хийх, техникийг урсгал зангилгааны аргаар засварлах, засварын газрыг техникчдийн шинийг санаачлах, зохион бүтээх, мөллөг мэргэжлээ дээшлүүлэх төв болгох, техникийг өндөр бүтээлтэй удаан ашиглахын үндэс болсон гурван дараалалт үйлчилгээний системийг тууштай нэвтрүүлэх нь чухал байна.

Үйлдвэрлэлийг шуурхай удирдлагаар хангахын тулд САА-нуудад диспетчерийн албыг байгуулж салааны системийг зохион байгуулалттай хийж аж ахуйн тооцоонд шилжүүлэн түүнийг СХ-ийн хөдөлгөөнтэй холбоовол зохино. 1973 онд газар тариалангийн талаар олсон амжилтаа улам бататган, атар газар эзэмшсэний 15 жилийн ойг хөдөлмөрийн өндөр амжилтаар утгах хөдөлгөөнийг тариаланчдын дунд өрнүүлэх хэрэгтэй.

ХАА-н үйлдвэрлэлийг шинжлэх ухааны үндэстэй хөтлөн удирдахад ахиц гарч дэвшилтэт арга барил нэвтэрснээр тайлангийн хугацаанд түүний эдийн засгийн үр дүн гарч байна. ХАА-н нийт бүтээгдэхүүн 61,7 хувиар, нэгдэл, САА-нуудын мөнгөн орлого 1973 онд 1970 оныхоос 2,7—42,1 сая төгрөгөөр нэмэгдэж, 1971, 1973 онд 4,6—26,2 сая төгрөгийн ашигтай ажиллав.

1973 онд нэг хүн өдөрт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, 1972 оныхоос нэгдэлүүдэд 6,2, САА-нуудад 64,2 хувиар өссөнөөр дундаж цалингийн өсөлтөөс хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт 76 хувиар түрүүлж, фонд өгөмж 22,9 хувиар дээшлэв.

Тайлангийн хугацаанд төлөвлөлт эдийн засгийн урамшууллын шинэ системд 3 аж ахуй шилжив. Энэ систем эдийн засгийн удирдлагын үр ашгийг арга болох нь нотлогдов. Жаргалант, Угтаал, Батсүмбрийн САА сүүлийн 2 жилд 4—6,7 сая төгрөгийн ашигтай ажиллав. Дээрхи аж ахуйнуудын үйлдвэрлэлийн ажиллагааны үр дүнг шинэ систем туршилтын өмнөх 1970 онтой зэрэгцүүлэхэд нийт ашиг 5 дахин, бүтээгдэхүүн 33,8 хувиар нэмэгдэж, фонд өгөмж 18, хөдөлмөрийн бүтээмж 39 хувиар дээшлэв.

Үйлдвэрлэлийн зориулалттай үндсэн хөрөнгийн төгрөг тутамд 61 мөнгөний бүтээгдэхүүн үйлдвэрлэн, улсын төсөвт 10,5 сая төгрөгийн нэмэгдэл хуримтлал орууллаа.

Гэвч ХАА-н үйлдвэрлэл эрчимжиж, эдийн засгийн үр дүн жигд сайжрахгүй байна.

Тайлангийн хугацаанд Баянцогтын САА 3 жилд, Баяндэлгэр, Баянцагаан, Дэлгэрхаан сумын нэгдэлд 2 жилд нь алдагдалтай ажиллав. 1973 онд ХАА-н нэгдлийн мал аж ахуйгаас орох орлого сүү, цөцгийн тос, ноосны төлөвлөгөө тасарснаас болж 1972 оныхоос 459,7 мянган төгрөгөөр буурчээ.

НАШБ-ын нарийн бичгийн дарга нарын улсын зөвлөлдөөн дээр шүүмжлэгдсэн дутагдлыг шийдвэртэй арилгаж ХАА-н үйлдвэрлэл, ялангуяа нэгдлүүдийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, удирдлагын хэмжээг шинэ шатанд гарган, аж ахуйг эрхлэх аргыг улам боловсронгуй болгох нь ХАА-н нэгдлийн намын байгууллагуудын чухал үүрэг мөн гэж тус бага хурал онцлон тэмдэглэж байна. Төлөвлөгөөний сахилга батыг зөрчих, материал техникийн хангамжийг таслах, нөөц

Үргэлжлэл нь IV пүүрт

Нөхөр Ц. АДЪЯА-гийн тавьсан илтгэлийн үргэлжлэл

Үргэлжлэл. (Түрүүч нь III нүүрт)

бололцоог үл дайчлах аж ахуйг биш үрэмт гий, хариуцлага санаачлагатай байгаа дутагдалд дүгнэлт хийвэл зохино.

ХАА-н нэгдэл, САА, үйлдвэр, аж ахуйн газрын үйлдвэр санхүүгийн төлөвлөгөө зохиож мөрдөх, ажилд намын хяналтыг тогтмол тавихын хамт тайлан балансыг шинжиж сурах, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авч түшиглэсэн газрынхаа чанарын үзүүлэлт эдийн засгийн үр ашгийг жилээс жилд сайжруулж удирдах нь НАШБ-ын нарийн бичгийн дарга нарын нэг гол үүрэг юм.

Аж ахуй, соёлын төлөвлөгөөг нэр төрөл, тоо чанарын өндөр үзүүлэлтээр биелүүлэх, ХАА-н бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, социалист өмчийг хамгаалж арвижуулах, анхан шатны бүртгэл тооцоог жинхэнэ ёсоор хөтлөх нь манай чухал зорилт мөн.

ХАА-н нэгдлүүдийн үйлдвэрлэлийн хэмжээг томсгох, САА-г төрөлжүүлэх замаар үйлдвэрлэлийн хэтийн төлөв, ашигтай хэмжээг тогтоож, эрчимжүүлэх ажлыг эрэмбэ дараатай хийх шаардлагатай байна.

Мөн үйлдвэрлэлийн нэгжид намын удирдлага нөлөөг хүчтэй болгох, төнд ажиллагсдын хариуцлага санаачилгыг нарийн тооцож, хүн бүртэй тулж ажиллах хэрэгтэй.

2. Үйлдвэр, барилга, тээвэр, холбоо, худалдаа үйлчилгээ

Үйлдвэрийн газруудын төлөвлөгөөг биелүүлэх, техник, тоног төхөөрөмжийн хүч чадлыг бүрэн ашиглах, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, ажилчдын мэдлэг мэргэжил, хариуцлага санаачилгыг нэмэгдүүлж, нөөц бололцоог бүрэн ашиглан эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх явдал тайлангийн үеийн гол зорилт байлаа. Аймгийн Намын хороо, үйлдвэрлэлийн тогтоо асуудлыг шийдвэрлэхэд коммунистууд, мэргэжилтэн, хариуцлагатай хамт олны хүчийг төвлөрүүлж ажиллав.

Манай үйлдвэрүүдийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх таван жилийн төлөвлөгөөний эхний 3 жил 5 сарын төлөвлөгөөг 63,5—81,2 хувиар биелүүлэн, V таван жилийн төлөвлөгөөний эхний 3 жилийн ашиг, өмнөх таван жилийн мөн үеийнхээс 13,0—660,0 мянган төгрөгөөр нэмэгдэв. Үүний дотор хүнсний үйлдвэр нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөөг сүүлийн 3 жил дараалан 102,7—127,6 хувь, V таван жилийн төлөвлөгөөний 87,3 хувийг биелүүллээ.

Тус үйлдвэрийн хөдөлмөрийн бүтээмж 1970 оныхоос 2,6 хувь дээшилж, бүтээгдэхүүний өөрийн өртөг 18 хувь, нэг төгрөгт ноогдох зардал 7 мөнгөөр буурч, фонд өгөмж 31 мөнгөөр ахижээ. Барилга угсралтын контор, ЗХУ-ын барилгын 3 дугаар трестийн туршлагыг судалж, өнгөлгөн өрлөгийг хэвтээ босоо, гурвитай өрөх ажиллагааг нэвтрүүлж байна. V таван жилийн төлөвлөгөөт барилга угсралтын 60,7 хувийг гүйцэтгэн, 11070,0 мянган төгрөгийн ажил илүү хийсний 89,6 хувийг хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтөөр хангажээ.

Барилга, ойн үйлдвэрлэлийн гол зорилт бол ажилчдын тоог нэмэгдүүлэн тогтворжуулж мэргэжил дээшлүүлэх, хөд мэргэжил эзэмших, үйлдвэрлэлийг механикжуулах, хөдөлмөрийн сахилгыг бэхжүүлэхийн дээр барилгын хийцийг дутуу, чанар муутай хийснээс ашиглалтанд өгөх хугацааг сунах, дахин хийж үргүй зардал гаргадгийг эцэс болгох явдал мөн.

Аймгийн эрчим хүч хэвлэх салбар, НААҮГ-ын төлөвлөгөөт зорилт амжилттай биелэгдэж V таван жилийн төлөвлөгөөний 70,1—73,2 хувийг гүйцэтгээд байна. Хэвлэх үйлдвэр бүтээгдэхүүний чанарын талон, гэрчилгээ олгох, мандатын уралдаан зохиох зэрэг хамт олны идэвхийг өрнүүлсэн ажил зохиож байна.

Хөдөлмөрийн хамт олны улс төр, хөдөлмөрийн идэвхийг өрнүүлэх, ажлын хариуцлага, сахилга батыг жигд дээшлүүлэх, хөдөлмөрийг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах, үйлдвэрлэлд тэргүүн туршилага, шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах явдал эдгээр байгууллагын чухал зорилт болж байна. НААҮГ, үйлчилгээний соёлч байдал эзэмшиж захиргаа авах дэвшилтэт хэлбэр гэрээр ба дуудлагаар хөдөөгийн хүн амд ахуйн үйлчилгээг хэрэглэх явдал чухал байна.

Аймгийн Намын хорооны удирдлага санаачилгаар тээвэр, холбоочдыг хөдөлмөрийн баатар, тэргүүний хүмүүстэй уулзуулан зөвлөгөө өгүүлж, туршлага судлуулав.

Мөн тээвэрчдийн дунд сар бүрийн сүүлийн хоёр өдрийг тэдний техник, мэргэжил, улс төрийн мэдлэгийг дээшлүүлэх өдөрлөг зохиож байна. Тээврийн байгууллагуудад саятан бригад 5 байгуулагдаж, бүх тээвэрчдийн 84 хувь нь хамрагдав. Авто-тээврийн бааз V таван жилийн ачаа эргэлтийн төлөвлөгөөний 63,1 хувь, зорчигч эргэлтийн 76,5 хувийг гүйцэтгэж, 1970 оныг 1973 онтой харьцуулахад парк ашиглалтыг 7, даац ашиглалтыг 8,1, хөдөлмөрийн бүтээмжийг 0,4 хувиар дээшлүүлэв.

Зам ашиглалтын ангийнхан энэ таван жилд 2,5 сая төгрөгийн ажил гүйцэтгэхээс 3 жил 3 сард 2,6 сая төгрөгийн ажил хийж, V таван жилийн төлөвлөгөөг 1 жил 9 сарын өмнө 103,3 хувиар биелүүлснийг бага хуралд баяртай мэдээлж байна.

Аймгийн харилцаа холбооны газар сүүлийн 3 жилд бүх үзүүлэлт 100—171,7, таван жилийн төлөвлөгөөний радио, зурагт радионы цэгийг 100,1, телефон 83,2, радио, хүлээн авагчийн 97,8, орлогын 73,0—87,8 хувийг гүйцэтгэжээ. Тээвэр холбооны салбарт бүртгэл тооцоо, хяналт шалгалт сул, үйлчилгээ шуурхай биш байгааг анхаарах хэрэгтэй.

Худалдаа бэлтгэл, нийтийн хоол, нийгэм ахуйн үйлчилгээний байгууллагуудад төлөвлөгөөт зорилтыг биелүүлэх, боловсон хүчний боловсрол мэдлэгийг дээшлүүлэн, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар зохиож байгаа ажил, социалист өмчийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах тухай асуудлуудыг Намын хорооны товчооны хурлаар хэлэлцэж байв.

Худалдаа үйлчилгээний байгууллагуудад анхан шатны бүртгэл, тайлан тооцоог сайжруулах зорилгоор ня-60 нарын зөвлөлгөөнийг хийж, Дорноговь аймгийн худалдааны байгууллагын туршлагыг судлуулав. Үүний дүнд худалдаа үйлчилгээнд хамтын тооцоотой бригад, өөртөө үйлчлэх тасаг, цуваа графикаар ажиллах дэвшилтэт арга хэлбэр нэвтэрч, хөрөнгө хамгаалалтыг сайжруулахын тулд ХБ-ийн ангилал барааны агуулах 23, арьс шир давслаганы байр 4-ийг байгуулав.

Төлөвлөгөөт зорилтоос сүүлийн 3 жилд бараа борлуулалт 100,5—103,1, ном 100,8—104,5, нийтийн хоол 101,0—108,3 хувиар, V таван жилийн төлөвлөгөөний бараа борлуулалтын 65,6, ном 66,5, нийтийн хоолны 60,2, ноос бэлтгэлийн 54,2 хувийг биелүүлсэн байна.

Ноосны 69 хувийг преслэн тээвэрлүүлж, бэлтгэлийн зүйлийн чанар 1973 онд 1970 оныхоос 16,5—17,3 хувиар дээшилжээ.

Гэвч ХБ-ийн байгууллагуудад тооллого, тооцоо муугаас өмч хөрөнгө үрэгдэх, улсын төлөвлөгөөг таслах, хөдөлмөрдөлд боловсон шуурхай үйлчлэх хүндэт үүрэгтээ хөшүүн хойрго хандах, хариуцлага алдах дутагдал амь бөхтэй оршиж байна. Худалдааны байгууллагуудад өр авлага 1970 оноос 600000 төгрөгөөр багассан боловч 1,3 сая төгрөгийн өр авлагатай байгааг анх дотор дутагдал шамшигдал 634,7 мянган төгрөг байна. Бараа таварыг бусдад зээлдүүлж нүүр тал засах зохисгүй үзэгдэл гарч байна. Сүүлийн 3 жилд хонины ноосны төлөвлөгөөг 117,3, тэмээний ноос 7,0, ямааны ноос, ноолуур 6,1 тоноор тасалжээ.

Худалдаа үйлчилгээний байгууллагуудын ажилчдын дунд зохиох хүмүүжлийн ажлыг хүчтэй болгож, боловсон хүчнээр бэхжүүлж, хүмүүсийн хариуцлагыг өндөржүүлэн ялангуяа агентын худалдааны үйлчилгээг эрс сайжруулан эд хариуцагчдыг шилэн сонгож тооллого, тооцоог үнэн зөвөөр хийж, ард олны эрэлт хэрэгцээг судлан ажиллах хэрэгтэй.

Бэлтгэлийн төлөвлөгөөг нэр төрлөөр биелүүлэх, түүхий эдийн чанар анхан шатны тордолт хийх, өмч хөрөнгө үрэгдэх шалтгааныг хааж, өр авлага хурааж барагдуулах дорвитой арга хэмжээг авч мал ноослох ажлыг цагт нь зохион байгуулалттай кампани болгон явуулахад олон түмний хүчийг татан оролцуулах арга барилыг эрс сайжруулбал зохино.

3. Ардын бэлтгэл, соёл, эрүүлний хамгаалал ажил

МАХН, сургуулийн насны хүүхдэд бүрэн биш дунд боловсрол эзэмшүүлэх, хөдөлмөрдийн ерөнхий боловсролын хэмжээг дээшлүүлэх, техник мэргэжлийн сургуулиар мэргэжилтэй ажилчид бэлтгэхийг чухалчилж байна.

МАХН-ын Төв Хороо, Сайд нарын Зөвлөл 1971 онд ерөнхий боловсролын сургуульд сургалтын шинэ систем нэвтрүүлэх тухай тогтоолын дагуу сургуулиуд сургалтын шинэ системд шилжин хичээллэж байна.

Мөн багшлах бүрэлдүүн дунд, дээд мэргэжлийн 160 гаруй хүнээр сэлбэгдэн, ажиллаж байгаа багш нарын 81,2 хувь давтан курст суралцжээ. Сургуулиудын материаллаг бааз өсөв. Суралчдын тоо 1970 оныхоос 1,5 хувь өсөв. 13-аг настай 81,2 хувь нь анхан шатны ба түүнээс дээш боловсролтой болжээ.

Гэвч хүүхдийн сурлага хүмүүжлийн чанар сулаас анги улирах, сургууль завсардах явдал байсаар байна. Хүүхэд багачууд гэмт хэргээр эерчилд өртөх үзэгдэл мөч сэр гарч байгааг анхаарч, сургалт хүмүүжлийн ажлыг сайжруулах, сургуулиас завсардуулахыг эцэс болгох хэрэгтэй. Багш нарын мэдлэг хүмүүжил, заах арга чадвар, сургууль цэцэрлэгийн материаллаг бааз, сургалтын чанар хүмүүжилд намын байгууллагын хяналтыг сайжруулбал зохино. Соёл урлагийн байгууллагууд V таван жилийн төлөвлөгөөний эхний 3 жилд уран бүтээл, киноны гаргалт, үзэгчид орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлэв. Гэвч клуб, улаан булан, танхимуудын ашиглалт муу, зарим нь хэвийн ажиллагаатай болж чадаагүйгээс хөдөөгийн хөдөлмөрдчийг урлаг, соёлоор үйлчлэх явдал хангалтгүй байна. Соёл урлагийн байгууллагууд аялаа тогтмолжуулан, уран бүтээлийн агуулага чанар, үзэл суртлын хэмжээ, хүмүүжүүлэх ач холбогдлыг дээшлүүлж, үйлдвэрлэлийн нэгжид үйлчлэх үйлчилгээг сайжруулах хэрэгтэй.

Эрүүлийн хамгаалах байгууллагууд 3 жилд амбулаторын үзлэг урьдчилан сэргийлэх тарилага, ор хоног ашиглалтын төлөвлөгөөнүүдийг биелүүллэв. Тайлангийн хугацаанд 1000 хүн амд нас баралт 0,5 хувь үүний дотор ялхасын эндэгдэл 14,5 хувиар буурч, цэвэр өсөлт 31 хувь байна. Гэвч хүүхдийн өвчлөлт зарим халдварт өвчний гаралт багасахгүй, эрүүл ахуй, ариун цэврийн байдалд онцны өөрчлөлт ороогүй байгаа нь МАХН-ын Төв Хорооны 1973 оны 118 дугаар тогтоолын хэрэгжилт төдий лсэйнгүйг гэрчилнэ.

Хөдөлмөрдчийн эрүүл энхийн үйлст бүх нийтийн анхаарлыг хандуулан дээрх тогтоол болон эрүүлжүүлэх төлөвлөгөөг биелүүлэхэд хамт олныг идэвхтэй оролцуулах, эмнэлгийн ажилчдын хариуцлагыг шаардлагын хэмжээнд тавьж үүнд нам, олон нийтийн хяналтыг сайжруулах хэрэгтэй.

Биеийн тамир спортын байгууллагууд бэхжин, гишүүдийн тоо 32, улсын зэрэгтэй тамирчид 13 хувиар өсчээ. Тэгэхдээ биеийн тамир спортыг зөвхөн сонирхогчдын хэрэг, тэмцээн оролцсон төдийгөөр үнэлж болохгүй.

Аж ахуйн байгууллагын зарим удирдагчид үүнийг гүйцэт үнэлэхгүй явцуурч амжилтаараа шалгарсан тамирчдыг дээд шатны тэмцээнүүдэд явуулахгүй, тамирчдын авъяас хүсэл эрмэлзэл, хөдөлмөрийн хамт олны бахархал коммунист хүмүүжилд саад хийсэн арчаагүй байдал гарсаар байгааг буруушаан тэмдэглэж байна. Хөдөлмөрдчийн эрүүл мэндийг сайжруулах, бие бялдрыг чийрэгжүүлэх, мэргэжлийн тамирчдыг төрүүлэхэд чиглүүлж, идэвхтэй амралт, өдөрлөг, аялал, нийтийн кросс уралдаан зэргийг албан газар, сумдын хооронд явуулах, үйлдвэрлэлийн гимнастикийг тогтмолжуулах, спортын мэргэжилтнүүдээс олон нийтэд үзүүлэх мэргэжлийн тусалцааг сайжруулах хэрэгтэй.

ХОЁР. Намын байгууллагын дайчлан зохион байгуулагч хүмүүжүүлэгч рөлийг улам дээшлүүлнэ.

МАХН-ын XVI их хурал, намын дотоод бэлтгэл хөгжүүлэн гишүүдийн сахилга, хариуцлагыг өндөржүүлж, намын бүх байгууллага, ялангуяа намын анхан шатны байгууллагын роль дайчин чадварыг дээшлүүлэн, намын шийдвэрийн биелэлтэд хийх шалгалтыг тогтмол үр нөлөөтэй болгохыг заасан билээ.

Аймгийн Намын хороо, анхан шатныхаа байгууллагуудын дайчин чадварыг дээшлүүлж, тэдгээрийг боловсон хүчнээр бэхжүүлэх, үйлдвэрлэлийн нэгжид гишүүдээ зөв байршуулж, манлайлал нөлөөг өндөржүүлэн, хөдөлмөрийн хамт олныг идэвхжүүлж хүмүүжүүлэхэд аялаа чиглүүлж ирвэ.

XV бага хурлаас хойш намын үүр 7, хэсэг 20-ийг шинээр байгуулж, одоо намын анхан шатны хороо 12, үүр 81, хэсэг 45 ажиллаж байна. Хоёр бага хурлын хооронд 265 хүн орлогч гишүүнээр элссэний 43 хувь нь ажилчин малчин, 40,3 хувь нь 30 хүртлэх насны хүмүүс.

(Үргэлжлэл нь V нүүрт)

Нөхөр Ц.АДЪЯА-гийн тавьсан илтгэлийн үргэлжлэл

Үргэлжлэл (Түрүүч нь IV нүүрт)

юм уу эвлэлийн эгнээнээс 150 гаруй хүн намд элссэн нь намд элсэгчдийн 54,8 хувь нь эвлэлээр дамжжээ. Намын бүрэлдүүнд эмэгтэйчүүд 29 хувь байна. Ажилчин малчдыг намд элсүүлэх талаар анхан шатны байгууллагуудын ажиллагаа дээшилснээр намын гишүүдийн 82,4 хувь нь материаллаг үйлдвэрлэлийн хүрээнд ажиллаж байна.

Одоо аймгийн хэмжээгээр 2220 гаруй гишүүд, орлогчид байгаа нь насанд хүрсэн 11 хүн тутамд намын 1 гишүүн оногдож байна.

Тэргүүний ажилчин, малчдыг ХЗЭ-ээр дахуулан элсүүлж, эгнээгээ өргөтгөх ажлыг цуцалтгүй сайжруулбал зохино.

Хоёр бага хурлын хооронд Намын хорооны бүгд хурлыг 7 удаа хуралдуулж, аж ахуй соёлын төлөвлөгөөт зорилтыг биелүүлэх, үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, мэргэжилтэн удирдах ажилтны хариуцлага сахилга батыг сайжруулах зэрэг асуудлыг хэлэлцжээ. Намын хорооны товчооны хурлыг 7—14 хоногт хийж, аймгийн аж ахуй, соёлын байгуулалтын хамгийн шаардлагатай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байв.

Нарийн бичгийн дарга нарын зөвлөлгөөнөөр тогтоол шийдвэрийн биелэлт, гүйцэтгэлийн шалгалтын тухай асуудлыг төлөвлөгөөтэй хэлэлцэж байна. Намын хурлуудын шийдвэрийг оновчтой болгох, түүний биелэлтийг зохион байгуулах, шалгах ажил дээшилснээр сүүлийн жилүүдэд аймгийн ажилд зарим ахиц гарч байна. Бага хурлуудын хооронд сонгодож, тайлагнах журам амжилттай хэрэгжиж, намын амьдралын Ленин хэм хэмжээг хэлбэрлэлтгүй биелүүлж ирвэ. НАШБ-ын тайлан сонгуулийн хурлуудад бүх гишүүд, орлогч гишүүдийн 86,8 хувь нь оролцон, 500 гаруй хүн санал шүүмжлэл гаргалаа. Эдгээр хүмүүс хамт олноороо, социалт уралдаанд үүрэг амлалт авах, нам, улс, олон нийт, аж ахуйн байгууллагын үйл ажиллагаанд оршиж байгаа дутагдал, түүний шалтгааныг илчлэн засах арга зам шийдвэрлэх гол зорилтыг заагаад хэрэгжүүлж байна. НАШБ-ын нарийн бичгийн дарга нарын улсын зөвлөлгөөнд шүүмжлэгдсэн Лүн сумын намын байгууллага дутагдалдаа дүгнэлт хийж, намын хурлын үүрэг ач холбогдлыг сайжруулан сумын нийт ажилд сүүлийн үед зарим ахиц гарч эхэлж байна.

Намын хурлыг таслах, бэлтгэл муутай хийж, үйлдвэрлэлийн гол асуудлыг хангалтгүй хэлэлцэх, үйлдвэрлэлд өөдтэй нөлөө үзүүлэхгүй байх, тогтоол төлөвлөгөөг гүйцэтгэлээр нь тооцдоггүй дутагдлыг тууштай засах нь намын анхан шатны байгууллагуудын үүрэг мөн. Аймгийн намын байгууллагууд, коммунистуудын гаргасан санаачилгыг дэмжиж, тодорхой ажил эрхэлсэн гишүүдтэй төрөлжүүлэн уулзаж зөвлөхөө өгөх, ажлы нь гүйцэтгэлтэй орон дараалан судаж, арга туршлагыг нэгтгэн дүгнэж мэдээлэх арга хэмжээ авч ирлээ. Намын үүр хороод ч гишүүдийн манлайлагч дээшлүүлэхийн тулд нилээд ажил зохиож байна. Тайлангийн хугацаанд үйлдвэрийн газар ажилладаг намын гишүүдийн 79,8—80,7, тариалангийн үйлдвэрлэлд ажиллагсдын 90,9—91,5 хувь нь төлөвлөгөөгөө биелүүлсэн ба давуулжээ. Намын малчин гишүүдийн 60,0 гаруй хувь нь малынхаа төлийг МАХН-ын Төв Хорооны IX бүгд хурлын шийдвэрт хүргэж бойжуулав. Мөн хугацаанд намын гишүүдийн дайчин эгнээнээс БНМАУ-ын хөдөлмөрийн баатар 8 төрөн гарчээ. Алдарт нэхмэлчин В.Гүн-жиламын туршлагаар намын гишүүн Ц.Хорлоо, Г.Алтанхүү нар болон Ж.Пүрэвэгийн удирдсан ногооны бригадын хамт олон ХАА-д анх түрүүн, удаан жилээр тооцоотой үүрэг авч эхний 3 жилд 5—11 жил 7 сарын ажил гүйцэтгэв. Аймгийн хэмжээгээр таван жилийн төлөвлөгөө биелүүлэгчдийн 40-өөд хувийг намын гишүүд эзэлж байна. Гэвч 1973 оны бүх ард түмний социалт уралдаанд намын гишүүдийн 9,6 хувь нь авсан амлалтаа биелүүлээгүй, намын гишүүн мэргэжилтний тал илүү хувь нь социалт уралдаанд тодорхой үүрэг амлалт аваагүй, ХАА-н нэгдлийн малчин гишүүдийн 61,4 хувь нь СХ-ийн хөдөлгөөнд хамрагдаагүй байна.

Хоёр бага хурлын хооронд, намын сахилга зөрчин 95 гишүүн, орлогчид арга хэмжээг авадганы 35,7 хувь нь 1—5 жил болсон гишүүн байна. Энэ бол намын анхан шатны байгууллагууд гишүүн бүртэй ялангуяа шинэ ги-

шүүдтэй ажиллах явдал хангалтгүй байгаагийн илрэл мөн. Бид намын гишүүдтэй нэг бүрчлэн ажиллах тэдний манлайлагч, бусад үзүүлэх нөлөөг дээшлүүлэхэд биетэй тусалцаа үзүүлэн социалт уралдаан, СХ-ийн хөдөлгөөнд бүрэн хамааруулж манлайлагч хариуцлагыг нь дээшлүүлэх гол хөшүүрэг болгох ёстой.

Намын ажлын шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах чухал хүчин зүйл болсон намын ажлын төлөвлөлтийг боловсронгуй болгож, биелэлтийн нь зохион байгуулах талаар зарим ахиц гарлаа.

Тайлангийн хугацаанд ЗХУКН, бусад ах дүү намууд болон Ховд, Говь-алтай, Завхан зэрэг тэргүүний аймгийн намын байгууллагын туршлагыг төлөвлөгөөндөө тусган нэвтрүүлж байна. ЗХУКН-ын ажлын баялаг туршлагаас орчуулж ашиглах, аймгийнхаа НАШБ-уудын ажлыг харилцан шалгуулах зэргээр намын ажлын туршлага солилцуулж байна. Намын ажлын төлөвлөлтийг цаашид улам боловсронгуй болгож, хэтийн төлөвлөгөөг туршлагатай хүмүүсээр бүрдсэн комисс байгуулж, олон талын судалгаа шинжилгээнд түшиглэн боловсруулах нь зүйтэй.

Намын мэдээллийг тогтмолжуулан, шуурхай үнэн бодитой болгох талаар ахиц олов.

Тайлангийн хугацаанд аймгийн намын хороо, намын гишүүд, хөдөлмөрчдөөс олон тооны мэдээлэл хүлээн авч барагдуулав. Эдгээр мэдээлэл нь удирдах ажилтнуудын ажлын хариуцлага сахилга батыг сайжруулах, социалт өмчийг арвижуулж бэхжүүлэх, социалт хууль ёсыг хангахад чиглэгдэж байв. Мэдээ мэдээллийг шуурхай гаргаж, түнд дүгнэлт хийж ажиллах явдал манай аль ч байгууллагад дутагдалтай байгааг анхаарах хэрэгтэй.

Намын ажилтан боловсон хүчнүүд мэдээлэл бүрт нямбай хандаж, олон талаас нь шинжлэн дүгнэж ашиглалтыг сайжруулан, түүнийг удирдлага, хяналт шалгалт, хөдөлмөрдийг хүмүүжүүлэх дайчин хэрэгжүүлр болговол зохино. Аймгийн Намын хороо тогтоол шийдвэрийн биелэлтэнд тавих хяналтыг сайжруулах талаар нилээд ажил хийлээ. Энэ хугацаанд гол гол тогтоолуудыг хувийн хэрэгжүүлж, МАХН-ын Төв Хороо, Сайд нарын Зөвлөл, аймгийн Намын хорооны 220 гаруй тогтоолын 340 шахам заалт хяналтанд авч 44,1 хувьд карт хөтлөн, 70 шахам заалтын жинхэнэ гүйцэтгэлийг гаргаж хяналтаас хасав. ЗХУКН-ын ажлын туршлагаар мэдээлэл, эрэлт хүсэлтэнд асуудлын байдал, шийдвэрлэх хугацааны шаардлагаар гурван өнгийн карт хөтөлдөө болов. Аймгийн Намын хороо, хэлтэс, тасгийн эрхлэгчид, зохион байгуулагчдын үзлэгийг намын анхан шатны байгууллагын ажилд хийж байв.

Шалган зааварлах ажлын үр нөлөөг сайжруулахын тулд зааварлах ажилтны нэгдсэн групп байгуулан ажиллуулж байна.

Тайлангийн хугацаанд тус аймагт 1100 гаруй гишүүд идэвхтэнтэй ардын хянан шалгах 39 групп, 120 пост байгуулагдсан нь нам, засгийн шийдвэр, улсын төлөвлөгөөг биелүүлэх, хүмүүсийн ажлын хариуцлага, сахилга батыг өндөржүүлэх, социалт өмчийг арвижуулах тэмцэлд үр нөлөөтэй хүч болохоо харуулав. Намын хорооны удирдлага туслацаатайгаар 1973 онд аймгийн ардын хянан шалгах байгууллага, нийгмийн малын дутагдал шамшигдал, тариа ногооны хянгдлыг багасгахад ажлаа чиглүүлэн нилээд хэмжээний зөрчил хохирлыг арилгав. Гэвч хянан шалгах ажлын дайчин шуурхай, ажил хэрэгч байдал, үр дүн тэр бүр сайн биш, анхан шатны байгууллага жигд ажиллаж чадахгүй байна.

МАХН-ын Төв Хороо, сумдын ардын хянан шалгах группүүдийг АХШХ болгон САА, нэгдлийн тасаг бригадуудад групп байгуулж, сум-нэгдлийн АХШХ-ны даргын ХАА-н нэгдлийн хянан байцаах комиссын даргатай хавсарган орон тооны болгосон нь хяналтын байгууллагыг бэхжүүлж, ажиллагааг нь сайжруулахад өргөн бололцоо олгов.

АХШБ-ууд дээд байгууллагын удирдамж, шийдвэрийг хэрэгжүүлэх, улсын төлөвлөгөөг биелүүлэх, хариуцлагыг газар сайгүй өндөржүүлэх хэрэгтэй. Намын байгууллагуудаас эдгээр байгууллагын ажлыг удирдах удирдлага, үзүүлэх туслацааг бүх талаар сайжруулбал зохино. АХШ төв байгууллагаас явуулж байгаа малын зүй бус хорголдог багасгах, үйлдвэр барилгын материал зарцуулалтын бүх нийтийн үзлэг, газар тариалангийн үйлдвэрлэлийн чанарт хийгдэх шалгал-

тыг сайн явуулж, үр дүнд хүргэх явдал чухал байна. ЗХУКН-ын байгууллагуудын туршлагаар аймгийн Намын хорооны шинээр сонгогдох гишүүдийг бага хурлын шийдвэр биелүүлэх гүйцэтгэлийг шалгаж байхын тулд тодорхой комисст хуваарилан ажиллуулах нь зүйтэй байна. Намын XVI их хурал, боловсон хүчнийг хүмүүжүүлэхдээ эрхэлсэн ажлын хариуцлагыг дээшлүүлэх, ам ажил хоёр зөрөхгүй байх явдлыг хангах, дутагдал гаргасан хүмүүст хатуу шаардлага тавихад анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй гэж онцлон заасан билээ.

Аймгийн Намын хороо, 1971 онд «МАХН-ын Төв Хорооны II бүгд хурлын дүн, аймгийн намын байгууллагын зорилтын тухай» бүгд хурлаараа хэлэлцэж, боловсон хүчинтэй ажиллах ажлыг сайжруулах, арга чиглэлийг тодорхойлсон юм. Мөн боловсон хүчнүүдийн улс төр, эдийн засаг, эрхэлсэн ажлын мэдлэгийг үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоон дүгнэж, ажилд нь туслах сургах ба давтан бэлтгэх, туршлага судлуулах, курс семинар үйлдвэрлэлийн зөвлөлгөөн хийлгэх ажлыг жил бүр төлөвлөгөөтэй зохиож байна.

1971—1973 онд аймгийн хэмжээгээр 1,5 мянган мэргэжилтэн хариуцлагатан улс төр, эрхэлсэн ажлын мэдлэгээ дээшлүүлэх 2 жилийн төлөвлөгөөтэй ажиллаж, орос хэлний 60 гаруй дугуйланд 1000 гаруй хүн суралцав.

Мэргэжилтний нэгдсэн ба төрөлжсөн зөвлөлийг аймаг, сумд байгуулан ажиллуулав. Мэргэжилтний боловсон хүчнийг 5—10 жилийн судалгаатай болгож, тайланг нь хөдөлмөрчдөд тавиулах, сорилт туршилт хийлгэх ажил зохиосны дүнд эрдэм шинжилгээний бүтээл туурвих эхлэлт тавигдаж байна.

Боловсон хүчнийг тогтвор суурьшигтай ажиллуулах, намын ажилтнуудыг дээд боловсролтой хүмүүсээр бэхжүүлэхэд анхаарал тавьснаар тайлангийн хугацаанд ХАА-н нэгдлийн дарга, намын үүр, хороодын нарийн бичгийн дарга нарын дотор дээд боловсролтой хүмүүс 11,1 хувиар нэмэгдэв.

МАХН-ын Төв Хорооны II бүгд хурлаас хойш мэргэжилтэн хариуцлагатнуудын 89,4 хувийн тайланг намын байгууллагуудаар нь хэлэлцүүлэн үнэлэлт өгүүлж, инженер, техникийн ажилтнуудаар бүтээх төлөвлөгөөг зохиолгож түүний үндсэн дээр социалт уралдаанд тодорхой үүрэг амлалт авахуулах журм тогтоов. Гэвч манайд ажил хэрэгт эзний ёсоор хандахгүй байх, намын байгууллагын хяналтын гадуур хүмүүсийг дур мэдэн сольж шилжүүлэх зэрэг зохисгүй дутагдлыг засах хэрэгтэй. Ялангуяа ТМС, сургуулийн комбинат төгссөн мэргэжилтэй залуу ажилчид, ХЗЭ-ийн илгээлтийн эзэд, сургууль шинээр төгсөгчдийг соёл ахуйн нөхцөлөөр хангаж суурьшигтай ажиллуулахад муу анхаарч байна. Мэргэжилтнүүд эрхэлсэн ажлынхаа талаар хэд хэдэн жилийн судалгаатай болсон боловч түүндээ түшиглэж доголтой асуудлыг засах арга замаа боловсруулан хэрэгжүүлэх явдал хангалтгүй байна.

Одоо манай аймгийн мэргэжилтэн хариуцлагатан нийт боловсон хүчний 74,5 хувь нь нэгдэл, САА дахь намын байгууллагын хүрээнд хамрагдаж байна.

Ийм учраас тэнд мэргэжилтнүүдийн ажлын үүрэг хуваарийг нарийсгах, үйлдвэрлэлийн технологийг төлөвлөгөөтэй мэдүүлэх, зун намын улиралд тайвширч мал, төл хоргоудууд даг ноцтой дутагдлыг арилгах талаар социалт уралдаанд тодорхой үүрэгтэй оролцуулж тогтмол дүгнэх, арга туршлагыг нь солилцуулах ажлыг идэвхжүүлэх хэрэгтэй.

Нөгөө талаар бригад, тасаг, үйлдвэрийн цехийн удирдах ажилтны ажлын хариуцлага үр нөлөөг дээшлүүлэх, бас авьяаслаг зохион байгуулагчдыг сонгон олж, тэднээр олон нийтийн даалгавар гүйцэтгүүлэх, ажилд нь туслах, мэдлэг боловсролыг нь дээшлүүлэх системтэй ажил зохиох хэрэгтэй байна.

Тайлангийн хугацаанд БНМАУ-ын Ардын Их Хурал, аймаг, хот, район, сум, хороодын депутатуудыг сонгох сонгууль амжилттай явагдав. Аймаг сумдын чуулганы ажил хэрэгч байдал дээшилж, гаргасан шийдвэр, шүүмжлэл, захира даалгавар, асуулгын мөрөөр арга хэмжээ авах явдал сайжрав.

АДХ-ын дэргэд намын хэсгүүд байгуулсан нь намын байгууллагаас төрийн эрх барих орон нутгийн байгууллагыг удирдах

(Үргэлжлэл нь VI нүүрт)

Нөхөр Ц. АДЪЯА-гийн тавьсан илтгэлийн үргэлжлэл

Үргэлжлэл. (Түрүүч нь V нүүрт)

удирдлагыг хүчтэй болгож, намын гишүүн депутатын манлайлал, үлгэр жишээч ажиллагааг хангахад түлхэц өгөх ёстой.

Төрийн байгууллагыг намын гишүүд, боловсон хүчнээр бэхжүүлэн АДХ-ын дэргэдэх намын хэсэг, байнгын комиссыг тодорхой удирдлагаар хангаж, үйл ажиллагааг нь дайчин шуурхай, үр бүтээлтэй болгоход намын байгууллага чухалчлан анхаарах ёстой.

Аймгийн Намын хороо социалист хууль ёсыг сахиулах, гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар идэвхтнийхээ хурлаар хэлэлцэж нилээд ажил зохиолоо.

Гэвч гэмт хэрэг зөрчилхн тоо тогтвортой буурахгүй байгаа бөгөөд социалист өмчийн хэрэг нэмэгджээ. Нам, улс хөдөлмөрийн сахилга батыг бэхжүүлэх, хөдөлмөрчдийн хууль эрхийн хүмүүжлийг дээшлүүлэн хууль тогтоомжийн биелэлтэнд тавих хяналтыг сайжруулах хэрэгтэй. Аймгийн Намын хороо, эвлэл, үйлдвэрчин, эмэгтэйчүүд, МЗН зэрэг олон нийтийн байгууллагуудын зохион байгуулалт үзэл суртлын ажлыг сайжруулах, эгнээг өргөтгөх, боловсон хүчнээр бэхжүүлэх, залуу үеийг ахмадын хувьсгалт хөдөлмөрч дайчин уламжлалаар хүмүүжүүлэх, ажилчин анги, хөдөлмөрчин эмэгтэйчүүдийн дунд зохиох улс төр, олон түмний ажлын цар хүрээг өргөтгөж, үр нөлөөг дээшлүүлэх, бүх нийтийг хамарсан социалист уралдааныг удирдах агуулга, хэлбэрийг баяжуулж таван жилийн төлөвлөгөөг биелүүлэх тэмцэлд олон түмний хүчийг дайчлан зохион байгуулахад үйл ажиллагааг нь чиглүүлэн ажилд нь өдөр тутмын удирдлага тусалцаа үзүүлж ирвэ. Манай яруу алдарт залуусаас намын урва, эвлэлийн илгээлтээр 1000 гаруй охид хөвгүүд үйлдвэрлэлд гарч ажилласны дотроос 64 нь улс, аймаг, сумын аварга «Эвлэлийн тэргүүний ажилчин, малчин» алтан медальтан боллоо. Аймгийн УЭ-ийн байгууллага, бүх ард түмний социалист уралдааныг өрнүүлэх, ажилд мэргэжилтнээр тооцоотой үүрэг авахуулах ажилд идэвхтэй оролцож байна.

Тайлагчийн хугацаанд СХБ, төлөө бригад, ССН-д хамрагчдын тоо 5300 гаруйгаар нэмэгдэж, аймгийн хэвлэх үйлдвэр, зам ашиглалтын анги СХ-ийн хамт олон болов.

Одоогийн байдлаар 100 гаруй хүн 5 батүүнээс дээш жилийн ажил хийгээд байна.

Эдийн ажилт туршлагыг товойлгон тавьж олон түмэнд дууриалал, нийтийн хүртээл болгоход их анхаарвал зохино. Олон нийтийн байгууллагын гол зорилт бол гаргасан шийдвэрийнхээ гүйцэтгэлд байнгын хяналт тавьж, үр дүнг тооцох, анхан шатныхаа байгууллагын ажлыг жигд сайжруулах, ажлын хувь заяа шийдвэрлэгдэж байгаа үйлдвэрлэлийн нэгж бригад, суурь, цех, тасагт ажилладаг хөдөлмөрийн хамт олныг идэвхжүүлэн хүмүүжүүлэх, улсын төлөвлөгөө, уралдааны үүргийн биелэлтийг хангах ажлыг сайжруулахад оршино.

Намын улс төр, үзэл суртлын ажил

Аймгийн Намын хороо улс төр, үзэл суртлын ажлаа МАХН-ын XVI их, Намын Төв Хорооны бүгд хурлууд, тэргүүний суртал нэвтрүүлэгч, ухуулагчдын II зөвлөлгөөн, НАШБ-ын нарийн бичгийн дарга нарын олсын зөвлөлгөөний шийдвэрийг удирдлага болгон төлөвлөгөөт зорилтыг биелүүлэхэд чиглүүлэв.

Намын хорооны бүгд ба товчооны хурлаар намын улс төрийн сургуулийг шинэ системээр зохион байгуулах, малчдын дунд зохиох соёл хүмүүжил, ахуйд соёл нэвтрүүлэх, ерөнхий боловсролын сургуульд сургалтын шинэ систем хэрэгжүүлэх, малчдыг радиожуулах зэрэг асуудлууд хэлэлцэж гаргасан шийдвэрээ зохион байгуулж байна. Аймгийн намын байгууллагууд намын улс төрийн сургууль, малчин гишүүдийн улирлын сургуулийг шинэ системийн дагуу явуулж 3 дахь жилдээ амжилттай дуусгаж байна. Намын гишүүд, орлогчдын улс төрийн сургууль, онолын семинаруудад дэвшин суралцах хуваарийг намын байгууллагаар батлаж суртал нэвтрүүлэгчдийг сонгон мэргэжүүлэхэд чиглэсэн олон төрлийн ажил зохиов.

Суртал нэвтрүүлэгчдийн 97,4 хувь нь намын гишүүд, 75 хувь нь дээд боловсролтой байна. Малчин гишүүдийн улирлын сургууль тогтмолжиж 80-90 хувийг хамран суралцуулж

байна. Аймгийн Намын хороо олон нийтийн байгууллагуудын улс төрийн сургууль, дуулиангуудын явцад хяналт тавьж, суртал нэвтрүүлэгчдэд мэргэжлийн сэхээтэн, удирдах ажилтнуудыг томилон төрөлжсөн семинар, зөвлөлгөөн, туршлага сургууль зохиож заах аргыг нь баяжуулж байна.

Хөдөлмөрчдийн дунд зохиох лекцийг хүн амын давхарга, ажил мэргэжлийн байдлаар төрөлжүүлж, аппарат хэрэгсэл, кино, аман сэтгүүл, үзүүлэнтэй явуулдаг болов.

Гэвч улс төрийн сургууль, онолын семинар, малчин гишүүдийн улирлын сургууль, семинарыг таслах, хичээлийн чанар программын шаардлагыг бүрэн хангахгүй явдал байна.

Баяндэлгэр сумын намын хороо 1973—1974 оны хичээлийн жилд намын улс төрийн сургуулийн сургалтын системийг алдагдуулан хичээллэвэл зохих онолын семинарыг тасалдуулсан байна. Хөдөлмөрчдийн эдийн засгийн боловсролын төвшинг нэмэгдүүлэх үндсэн хэлбэр болсон СХ-ийн сургуулийг үйлдвэрлэлтэй нягт уялдуулж үйлдвэрлэлд үр нөлөө үзүүлэхийг бүтээл арга хэлбэрээр заахыг чухалчилбал зохино. Туршлага, судалгаа шинжилгээний цогцолбор бүхий бааз үзүүлэн сургууль байгуулж, нээлттэй хичээл, шинжлэх ухаан техник тэргүүн туршлагын онол практикийн бага хурал зохиож байвал зохино.

СХ-ийн сургуулийн заах арга зүйг боловсруулж, төрөл бүрийн мэргэжлийн болон тэргүүний хүмүүсээр бүрдсэн секц байгуулан ажиллах нь зүйтэй. Аймгийн Намын хороо мэргэжлийн ухуулагчаар БНМАУ-ын хөдөлмөрийн баатрууд, тэргүүний сайчууд 19 хүнийг батлан ажиллуулав. Намын байгууллагуудад удирдах ажилтан, мэргэжилтэн дээд боловсролтой хүмүүсээр бүрдсэн 400 гаруй хүнтэй улс төрийн мэдээлэгчдийн хэсэг ажиллах болов. Ухуулагчид улс төрийн мэдээлэгчдийн туршлагыг нэгтгэн дүгнэж харилцан солилцуулах зорилгоор аймгийн Намын хороо 2 жил тутам ухуулагчдын бүсчилсэн семинар зөвлөлгөөнийг зохиож байна.

«Ухуулагчдад тусламж» хуудас, аймгийн хөдөлмөрийн «аваргууд», «Тэргүүний суртал нэвтрүүлэгч, ухуулагчдын туршлага» зэрэг товхимол, «Ухуулагчдад тусламж» болон цаг үеийн сэдвээр зурагт ба ухуулах хуудас гаргаж ухуулагч, улс төрийн мэдээлэгчдэд туслаж байна.

Мал өвөлжилт, төл бойжуулалт, хадлан тэжээл бэлтгэлт, тариа ногоо тариалт, хураалтын үеэр зохиох ухуулга соёл хүмүүжлийн ажлын нэгдсэн төлөвлөгөөг гаргаж улирал тутам аймаг, сумаас ухуулга-соёл, үйлчилгээний бригадууд гарган ажиллуулж ирлээ.

Гэвч ухуулгыг аймаг, сум, албан байгууллагын зорилт, түүний биелэлтээс тасархай явуулдаг, ухуулагчидтай байнга тодорхой ажилладаггүй дутагдал Баян, Баянцагаан сумдын намын байгууллагуудад байсаар байна.

Айл өрх, суурь малчил ялангуяа эмэгтэйчүүд, гэрийн ажилтай хүмүүст нам, засгийн бодлого цаг үеийн зорилтыг хүргэж сурталчлах ажил хангалтгүй, ухуулгад тэргүүн туршлага, үзүүлэн, техник хэрэгсэл хэрэглэх явдал дутагдалтай байна.

Намын байгууллагууд ухуулагчидтай тодорхой ажиллаж семинарын чанарыг сайжруулан ажлыг нь дүгнэн, намын гадаад дотоод улс төрийн бодлого, улсын төлөвлөгөөг биелүүлэх, аймаг, сум, бригад, суурь, албан газрын тодорхой зорилт, түүнийг хэрэгжүүлэх арга, үйлдвэрлэлийн технологи, уралдааны үүрэг амлалт, биелэлт, тэргүүн туршлага, уралдаанд түрүүлэгчийг алдаршуулах, юу бүтээгээд ямар хөлс урамшил авах гэх зэрэг тодорхой зорилтыг хүн бүрт хүргэж үнэмшүүлэхийг үр нөлөөтэй явуулахад бүхий л ажиллагаагаа чиглүүлэх ёстой.

Үйлдвэрлэлийн ухуулгад тэргүүн туршлага, үзүүлэх сургууль бодитой нөлөө өгөх учир энэ хэлбэрийг өргөн хэрэглэвэл зохино.

Малчдын дунд зохиох улс төр, соёл хүмүүжлийн ажлын чухал хэлбэр бригадын өдөрлөгийг аймгийн Намын хорооны хөтөлбөрөөр сар бүр явуулж тогтмолжиж, Баянжаргалан, Баян-Өнжүүл сумдад өдөрлөгийг залуучууд, эмэгтэйчүүд, адуучид, төлчдийн гэх зэргээр төрөлжүүлэн явуулж соёл үйлчилгээний ажлыг хамтатгаж байна. Өдөрлөгт хүмүүсийг жигд оролцуулж, уралдаан дүгнэх, соёл урлагаар үйлчлэх ажлын чанар арга барилыг байнга сайжруулж ажиллах хэрэгтэй.

Суурийн хүмүүжлийн ажил хөдөөгийн хөдөлмөрчдийн эдийн засгийн боловсрол дээшлүүлэх үндсэн хэлбэр мөн. Суурийн хүмүүжлийн ажил өнгөрсөн оноос шинэ хөтөлбөрийн дагуу хичээллэж 1373 суурийн 5600 шахам хүн хамран суурьтаа ба суурь дундын хэлбэрээр зохион байгуулж байна. Өндөрширээт, Заамар, Жаргалант сумдын намын байгууллагууд энэ ажлыг сайн зохион байгуулан ажиллаж байна. Суурийн хүмүүжлийн ажлыг чанаржуулахын тулд удирдах ажилтан, сэхээтнүүдийг нэгдлийн бригадуудад зөвлөх багшаар томилон тусалцуулж байна.

Малчдын дунд зохиох улс төр, соёл хүмүүжлийн ажлыг цаашид сайжруулах зорилгоор МАХН-ын Төв Хорооны 1972 оны 134 дүгээр тогтоолын биелэлтэд аймгийн Намын хорооны товчооны үзэлг хийх болно.

Манай алдарт малчдын эгнээ залуучууд, илгээлтийн эздээр сэлбэгдэж байгааг харгалзан тэдний оюун санаа соёлын өндөр эрэлт шаардлагыг бүрэн хангахуйц ажил зохиох, шинэ мэргэжил эзэмших, ерөнхий боловсролоо дээшлүүлэх, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн ажиллагааны технологийг түргэн эзэмшихэд нь анхаарч туславал зохино.

Нам, засгаас хөдөлмөрчдийн эдийн засгийн боловсрол аж үйлдвэрийн ажилчдын мэргэжлийг дээшлүүлэх арга хэмжээний тухай чухал тогтоолууд гаргалаа. Дээрх тогтоолуудад аж ахуйг социалист ёсоор эрхлэх, үйлдвэрлэлийг удирдахад нийт олныг оролцуулах, хөдөлмөрчдийн эдийн засгийн мэдлэгийн төвшинг дээшлүүлэх ажлыг сайн зохион байгуулах явдал нь нам, улс, олон нийт, аж ахуй, соёлын байгууллагуудын чухал зорилт мөн.

Үзэл суртлын ажлын хүчирхэг зэвсэг—хэвлэл мэдээллийн хэрэгсэл өслөө. Хэвлэл захиалт жил дараалан нэмэгдэж байгаа нь хөдөлмөрчдийн соёлын төвшинг илтгэх нэг хэмжүүр юм. 1974 онд намын үнэн, аймгийн сонин, намын амьдрал, ухууллагч сэтгүүлийн захиалт 23,3 хувиар өсчээ.

Гэвч Баянцагаан, Баянцогт, Баянзүрх, Жаргалант зэрэг сумдад хэвлэлийг хөдөлмөрчдөд хүргэхгүй дарагдуулдаг явдал үзэгдсээр байна. Аймгийн «Анхдугаар таван жил» сонин агуулга үзэл суртлын хэмжээ сайжран, цаг үеийн зорилт, социалист уралдааныг сурталчлах талаар нилээд ажил зохинож.

Цаашид сонин агуулга, чанар, үзэмжийг дээшлүүлэн, уншигчдын тоог ахиулж хэвлэгдсэн материалын үр нөлөөг суллаг манай сум, байгууллага хэвлэлийн хуудсанд альбом хөтлөн хэвлэлийн шүүмжлэлийн мөрөөр тодорхой ажиллах хэрэгтэй.

Радио, зурагт радиогийн тоо жилээс жилд өссөөр байна. Сүүлийн 3 жилд радио цэг, хүлээн авагчийн тоо 2,5 хувь, зурагт радио 3 дахин нэмэгдлээ. Аймгийн Намын хороо энэ онд тэмдэглэх Монголын радиогийн 40 жилийн ойг утгаж хөдөөгийн айл өрхийг бүрэн радиожуулах зорилт тавиад ажиллаж байна.

Хөдөөгийн айл өрхийн 61 хувь нь радиотай байгаа нь шаардлагаас хоорцр, сумын төвүүдэд радио үзэлийн ашигдал хангалтгүй, цэгийн тоо чамалттай, нэвтрүүлэг тогтмолжоогүй байна.

Хөдөлмөрчдийн соёл хүмүүжлийн төв болсон клуб, улаан булангуудын материаллаг бааз нэмэгдэн Эрдэнэсант, Баяндэлгэр зэрэг нэгдлийн клубуудын үйл ажиллагаа сайжрах зөв эхлэлтэй байна. Мөнгөнмөрөт, Баяндэлгэр, Заамар, Жаргалант, Борнуур сумдын нүүдлийн киноны ажил сайжирчээ. Аймгийн хэмжээгээр хөдөлмөрчдийн ахуйн соёлжилтыг дээшлүүлэх 2 жилийн төлөвлөгөөтэй ажиллаж, төв хөдөөд ахуйн соёлын сургуулиудыг байгуулан хичээллүүлж хөдөөд ахуйн соёлжилтонд үзлэг явуулах зэрэг ажил зохиож байгаа боловч, ардын хувьсгалын 55 жилийн ойг утгаж ахуйд соёлч байдлыг хэвшүүлэх тухай Намын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлийн тогтоолын заалтыг хангах шаардлага тавигдаж байна.

Аймгийн Намын хороо, ЗХУКН-ын үзэл суртлын ажлын туршлагаас нилээд зүйлийг нэвтрүүлж байна.

Намын үзэл суртлын ажлыг хөдөлмөрийн хамт олныг идэвхжүүлж хүмүүжүүлэх, улсын төлөвлөгөөт зорилт, бүх ард түмний социалист уралдааны үүргийн биелэлтийг хөдөл-

(Төгсгөл нь VII нүүрт)

АМЖИЛТ ИЛТГЭСЭН РАПОРТ

«Анхдугаар таван жил» сонинны социалист хөдөлмөрийн хэвлэх үйлдвэрийн хамт олон бид аймгийн Намын XV бага хурлын шийдвэрийг биелүүлэхийн төлөө өөрсдийн хүч авъяасаа дайчлан ажиллаж ирвэ.

Аймагтаа анх удаа социалист хөдөлмөрийн үйлдвэр хэмээх хүндэт цол хүртэж, аймгийн хүндэт дэвтэрт хамт олноороо бичигдлээ.

1971—1973 оны үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 107,7—122,2 хувь, 1974 оны эхний хагас жилийн төлөвлөгөөг 6 дугаар сарын 20-ны байдлаар 111 хувиар биелүүлээд байна.

Манай хамт олон V таван жилийн төлөвлөгөөний эхний 3 жил 5 сард 3 жил 10 сар 20 хоногийн ажил хийснээ тус бага хуралд баяртайгаар илтгэв. 1971—1974 онд үйлдвэр аж ахуйн газруудын дунд зарласан социалист уралдаанд эхний байрууд эзэлж баярын бичиг, дин-

ломоор 7 удаа шагнагдаж, аймгийн 50 жилийн ой угтсан социалист уралдаанд 3 дугаар байр эзлэн, ойн нэрэмжит үүрд хадгалах туг, 3000 төгрөгөөр шагнагдсан юм.

Хамт олны дотор ЗХУ-д жуулчлах эрхийн олон мандатын төлөө уралдаан, ижил мэргэжлийн болон хөдөлмөрийн алдар уралдаан, Д. Сүхбаатарын нэрэмжит касс-дажиллахын төлөө зэрэг олон хэлбэрийн уралдаан зохиож ирсэн нь ийнхүү амжилт олох үндэс болов.

Манай хамт олон үйлдвэрлэлд «чанарын талон»-ыг хэрэглэсэн нь улсын хэмжээгээр нэвтэрч, нийгмийн социалист өмч бүтээгдэхүүнийг чанар сайтай гаргаж, материалыг үр ашигтай зарцуулахад эдийн засгийн ихээхэн ач холбогдол өгч байна.

Бидний 30,1 хувь нь МАХН-ын гишүүн, 24 хувь нь МХЗЭ-ийн гишүүн юм. Үйлдвэрлэлийн нэгж бүрт намын гишүүд ажил-

лаж, хамт олноо манлайлж байна.

МАХН-ын гишүүн Ч. Алтангэрэл, Ж. Дэжид, Д. Балжинням, МХЗЭ-ийн гишүүн Д. Лхагва, дэвтэрлэгч Даариймаа нарын олон сайчууд 1971—1974 оны жил бүрийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 107,3—132,6 хувиар биелүүлж ирэв. Манай тэргүүний хүмүүс цахилгаан хөрөө, цахилгаан үзэг, эх баригч, цавуу буцаагуур зэрэг олон зүйл санаачлан хийж үйлдвэрлэлд нэвтрүүлэв.

Энэ хугацаанд МХЗЭ-ийн XVI, МУЭ-ийн X их хурал, Шинийг санаачлагчдын болон зохиолчдын их хурал, бусад зөвлөлтөөнүүдэд II хүн оролцсон нь тус үйлдвэрийн түүхийг бахархалт үйл явдлаар байжууллаа.

Редакцийн хамт олон бид сонинны агуулга, үзэл суртлын хэмжээг дээшлүүлэх, түүний зохион байгуулах хүмүүжүүлэх ажлыг улам үр нөлөөтэй болгохын төлөө санаач-

лага идэвх гарган ажиллав. Манай сонин тайлангийн хугацаанд «Чанар гол үзүүдэлт», «Мал өсгөх нөөц бололцоо» бага хурал, орос хэлний болон коммунист ёс суртахууны хичээт явуулж социалист уралдааныг сурталчлах тэргүүн туршлага дэлгэрүүлэх, аж ахуй, соёлын зорилтыг биелүүлэхэд ихээхэн анхааран ажиллаж ирлээ.

Мөн ЗХУ болон ах дүү социалист орнуудын их ололт туршлагыг өргөн сурталчилж байна. Тус сонинны редакци 1973 онд төв орон нутгийн хэвлэл, радио, телевизийн редак-

цийн газруудын дунд социалист уралдааныг сурталчлах талаар зарласан, болзлыг хангаж 3 дугаар байр эзлэн Соёл Гэгээний ажилтны УЭ-ийн Төв хороо, Монголын Сэтгүүлчдийн холбооны динлом, 2000 төгрөгөөр шагнагдлаа. Манай хамт олон аймгийн Намын XVI бага хурлаас гарах шийдвэрийг өдөр тутмынхаа үйл ажиллагааны удирдлага болгон өмнөө тавигдсан үүрэг даалгаврыг нэр төртэй биелүүлж чадахаа илэрхийлэв.

«Анхдугаар таван жил» сонинны CX-ийн хэвлэх үйлдвэрийн хамт олон

ШАГНАЛ ОЛГОВ

Аймгийн Намын хорооны үзэл суртлын хэлтэс леки ярианы сэдэв бичиж боловруулсан хүмүүсийг шалгаруулав.

Үүнд: Аймгийн прокурор, гавьяат хуульч О. Лхамсүрэн, Баянжаргалан сумын малын их эмч Б. Очирбат, ЭХГ-ын ажил-

тан хүний их эмч Д. Гүндсамбуу, ХААУГ-ын зоо-техникч Т. Цэвээн, аймгийн УЭ-ийн зөвлөлийн ажилтан Д. Дуламжав нарт энэ оны эхний хагас жилийн леки бичлэгийн ээлжит шагнал олгов.

З. БАЯРБАТ

1 жил 6 сарын өмнө

Борнуур сумын кино механикч Н. Доолно V таван жилийн кино гаргалт, үзэгчид, орлогын төлөвлөгөөг хугацаанаас нь 1 жил 6 сарын өмнө 100 хувиар биелүүлсэн амжилтаар аймгийн Намын XVI бага хуралд бэлэг барив.

Д. Дамсцэрэн

ТАЛХНЫ АМТ

Босго алхангуут гурилын исгэлэн үнэр ханхныг жигнэсэн талхаа гарган вандан дээр өрсөн шинэхэн талх үелэн шаргалтана.

Хотынхоос дутах юм алга. Архустын талх амт чанар сайтай гэж зэргэлдээ сумынхан ярилцдаг. Салбарын эрхлэгч, мастераар 7 дахь жилдээ ажиллаж байгаа Ядамхүүгийн удирдсан энэ хамт олон жил дараалан төлөвлөгөөг 107—116 хувиар биелүүлж ирэв.

Тус салбарынхан энэ онд 70 тонн талх үйлдвэрлэх төлөвлөгөөг 10-тонноор давуулан биелүүлэх үүрэг аваад эхний хагас жилийн төлөвлөгөөг 20 хоногийн өмнө 107 хувиар биелүүлэв.

Талх сайн муу болох нь гурил зуурмаг хоёроос л шалтгаалдаг ажээ.

Зуурмагийг буруу хийснээс талх арзайж хагарах, түлэгдэх явдал гардаг.

Ялангуяа зун талхны гурилыг бүлээвэрт усаар зуурвал хөөх нь сайн байдаг.

Нэг кг талханд орох гурилын орц хэмжээг нарийн баримталж, асгах пүргүүлэх зэргээр хорогдол гаргалгүй ажиллаж жилд 300—400 кг гурил хэмнэж байна.

Манай ажилчин Хандсүрэн, Пүрэвсүрэн нар ажилд идэвх зүтгэлтэй сайн ажиллаж байгаагийн ачаар манай ажил өөдрөг байна гэж мастер Ядамхүү ярих.

Д. ОТГОН

АТРААС СОНССОН АЛДАР

(Шүтэглэсэн сурвалжлага)

Жаргалантын сангийн аж ахуйгаас Жаран ес машин хөдөлдөө Замынхаа өгч эвлэгхэн гаргаад Залуухан жолооч дуу аянаа Хагас онгойлгосон салхичийн завсраар Хаврын ногооны үнэр сэнгэнэж Уран зэрэглэлэнд зурвасласан талбай Усан цэргийн нам шиг эрээлжилнэ Жаран ес гэдэг машин хурдан Загдал ордог зам сайхан Хажуудах нөхөр минь ирнэ өдөж Хагалсан талбай тийшээ заагаад Тарианы тарган шаргал үрнийг Та алган дээрээ тавиад бодож үзэв үү? Нар газрын хамаг шинэ нь Найралдаж шингэснийг таниад ирэхлээр Агрономчийн заавар тариачны хөдөлмөр Амаргүй гэдэг илт шүү гээд Талхны хөрөнгө исгэх адил Тариалах хөрсөө боловсруулах нарийн Гэсгэлэн чийгэнд үрлэх амархан ч Гэрэл зураг авдаг шинг хугацаа эмээгхэн Острын малчин шиг завгүй явж л Онцгой тарган тариа хураадаг гэхэд Түргэн боломжийг бушуухан ашиглаж Түүх намтраас нь шалгаж гарлаа Энгэр дээр нь баатрын соёмбо Нүүрэн дээр нь инээмсэглэл тодорно Онцолсон мэргэжил нь трактор-комбайнч Одоо дөнгөж гучин настай гэнэ Багадаа би моринд дуртай Баасанхүү ахтайгаа хамт Суунаглах тоосны үзүүрт торойж Сургууль гэр хоёрынхоо хооронд уралдаж Архангайн Төвшрүүлэхийн САА-д Анх дөрөвдүгээр анги төгслөө Трактор гэдэг чадалтай унаа Тариа гэдэг амттай идээ Хүсэл сэтгэлийн минь жолоог Хүүхэд ахуйгаас минь татсан юм Гоцын тэр хүсэлдээ хүрч Гойдын сайхан мэргэжилд эзэмшлээ Атар гэдэг шинэ үг Амтад талх шиг дотно сонсогдож Эх орны дуудлагаар бид Эвлэлийн илгээлт өвөртлөөд гарлаа Тэгээд би Жаргалантад ирлээ Тэндээ ажиллах шийдвэр авлаа —Чигчийн чинээ биетэй байж Уулын чинээ санаатай хүү ч Юу ч гэсэн аравдугаар бригаданд оч Юм хум элбэлцэнэ биз Атарт шинээр байгуулагдсан бригаданд Ажил гэдэг хаанаас мундах вэ

Ус тос зөөлгөх төдийд Унуулчих хуучин трактор олдоно биз гэхэд Омог уур цээжинд буцаж Ойн түймэр шиг шатах дөхсөнч Хуучин тракторы нь жолоогч атгуут Хурам бүрийд шамдан ажилласаар Итгэл найдварыг хүндтэй хүлээж Ирэх жил нь шинийг авлаа Жиндүү хаврын хавсарган дундуур Жижигхэн гэртэй хээрийн бригаданд Аавын дээлийн илчийг мөрөөдөж Аяншиж гундан гэрээ санаач Тракторын хойноос агрегат угсраад Тарианыхаа үрнийг суулгаж эхлэхэд Бүгшиж байсан хөнгөн уйтгар Булдуулсан хөрсөнд ичээд үлдэхэд Өндийн соёлсон түүрүүтэй хамт Өр зүрхэнд хүсэл ургав Өөдтэйхэн ажиллавал юмыг яаж мэдэх вэ Өдрийн тэргүүн ч болохыг хэн байг гэхэд Хүслийнхээ жолооноос атган хурдалж Хүнээс дутахгүй амжилт гаргалаа Амжилт гаргаж уралдаанд түрүүлж Ажилд талгуулж амьдралд сурлаа Нарны өнгөөр шаргалтсхийгээд Намрын тариа шаргаад ирэхэд Хүн амьтан төөрмөөр ургацаа Хүчит комбайнаар хурааж явахад Эр хүний жаргал гэдэг Энэ талбайд байгаа юм шиг Алтан залаат тариан түрүүг Алган дээрээ тавин биширлээ Газар тариалангийн хамаг л сайхан Гарт минь атгагдах шиг сэтгэл сэргэлээ Галуу ирж тогоруу буцсаар Ээлжлэн хагалж тариа хураасаар Өргөж цаг хурдан өнгөрөхөд Энгэр дээр минь алтан соёмбо гялалзаж Эвлэлийн илгээлтийн илчийг мэдэрлээ Аваргын болзлыг дараалан хангаж Ардын хурлын депутат болж Анхны нөгөө 75-аараа Арван хоёр жилд их засваргүйгээр Хорин жил хагасын ажил хийлээ Ах минь ч гэсэн аварга боллоо Ажил хөдөлмөр ийм л сайхан Алдар нэрийг ингэж л өргөх юм Эгэл миний жаргал баяр Эрднийн алтан тарианаас Эхэлсэн юм даа гэж Жаран есийн давхил дунд Чойжамц баатар бахархан ярьсан юм Атраас сонссон алдраар нь нэрлэсэн Ахархан сурвалжлага ингэж бүтсэн юм

Ш. ЦЭРЭНДОО

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д. ТОВУУ